

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

2025 оны 12 дугаар сарын 02-ны өдөр

Орхон аймаг

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Зарцуул сан төсөв, эх үүсвэр /сая.төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, бодлогын удирдамжаар хангах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ хоорондын уялдааг хангаж, салбарын бодлоготой уялдуулах, салбарын чиглэлээр иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахимжуулах, хэрэглэгчдийг мэдээ, мэдээллээр хангах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн болон жижиг, дунд үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, шинжлэх ухаан, технологи, инновац, төлөвлөгөөний төслийг боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, зөвлөгөө өгөх.							
1.1.	Зорилт 1. Захиргааны удирдлагаар хангах, бүтцийн дотоод зохицуулалт, цаг ашиглалт, байгууллагын хүний нөөцийн бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангана. /Төрийн албаны тухай хууль, ЗГ-ын 2019 оны 74 дүгээр тогтоол “Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам”, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Жендерийн тухай хууль,	1. 1.6 Улсын төсөв 11.4 Орон нутгийн төсөв 2. 773.7 Улсын төсөв 5.5 Хамтын сан 900.0 бусад	1.Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь 2.Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	1. 100 хувь 2. 100 хувь	1. 100 хувь 2. 100 хувь	1. Хүнс, хөдөө аж ахуйн газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2025-2028 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, батлуулсан. Хөтөлбөрийн хүрээнд 2025 онд 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөг батлуулсан. Төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилт 95.5 хувь, жилийн эцсийн хэрэгжилт 100 хувьтай биелсэн. 2. Хүнс, хөдөө аж ахуйн газрын албан хаагчдыг чадавхжуулах 2025-2028 оны сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж батлуулсан. Хөтөлбөрийг 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг албан хаагчдыг чадавхжуулах, гадагш чиглэсэн сургалт гэсэн 2 төрлөөр боловсруулж, нийт 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилт 88.5 хувь, жилийн эцсийн хэрэгжилт 100 хувьтай биелсэн.	100 Бүрэн хангалттай

	ТЖҮЧ 5.2., ЗДҮАХ 4.3.1., 4.3.1.5./						
1.1.1 .	Арга хэмжээ 1. Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлд мэдээлэл оруулах.	-	1.Албан хаагчийн тоо 2. Мэдээллийн иж бүрэн байдал	1. 23 2. 100 хувь	1. 23 2. 100 хувь	1.Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн хувийн хэргийг хөтлөх журам"-ын хэрэгжилтийг хангах хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А/696 дугаар тушаалаар эхний хагас жилд 23, тус сайдын А/331 тушаалаар жилийн эцэст 21 албан хаагчийн үндсэн орон тоотойгоор ажиллаж байна. Албан хаагчдын хувийн хэргийн мэдээллийг системд 2 удаа баталгаажилт хийлгэсэн. Үүнд тэтгэвэрт гарсан-1, чөлөөлөгдсөн-1, хүүхэд асрах чөлөөтэй байгаа-2, одоо ажиллаж байгаа-21 буюу нийт 25 албан хаагчийг хамруулан хувийн хэргийн бүрдлийг нягтлан шалгаж, нөхөн бүрдүүлэлт хийн ажилласан. 2. Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 402, 498 дугаар тогтоолуудын хэрэгжилтийг хангах хүрээнд Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим санд албан тушаалын тодорхойлолтыг оруулж, Төрийн албаны зөвлөлөөр хянуулан баталгаажуулах ажлыг заасан хугацаанд бүрэн хийж гүйцэтгэсэн. Мөн цахим санд албан хаагчдын хувийн хэргийн мэдээллийг шинэчлэн, оруулж, албан хаагчдаар хянуулан 2 удаа баталгаажуулж ажилласан.	100 Бүрэн хангалттай
1.1.2 .	Арга хэмжээ 2. Байгууллагын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах.	1.6 Улсын төсөв 11.4 Орон нутгийн төсөв	Хэрэгжилтийн хувь	100 хувь	100 хувь	Хүнс, хөдөө аж ахуйн газрын албан хаагчдыг чадавхжуулах 2025-2028 оны сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж батлуулсан. Хөтөлбөрийг 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг албан хаагчдыг чадавхжуулах, гадагш чиглэсэн сургалт гэсэн 2 төрлөөр боловсруулж, нийт 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилт 88.5 хувь, жилийн эцсийн хэрэгжилт 100 хувьтай биелсэн.	100 Бүрэн хангалттай

1.1.3	Арга хэмжээ 3. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх.	773.7 Улсын төсөв 5.5 Хамтын сан 900.0 бусад	Хэрэгжилтийн хувь	100 хувь	100 хувь	Хүнс, хөдөө аж ахуйн газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2025-2028 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, батлуулсан. Хөтөлбөрийн хүрээнд 2025 онд 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн төлөвлөгөөг батлуулсан. Төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилт 95.5 хувь, жилийн эцсийн хэрэгжилт 100 хувьтай биелсэн.	100 Бүрэн хангалттай
1.1.4	Арга хэмжээ 4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Жендерийн хууль тогтоомжийн сургалт зохион байгуулах.	-	Зохион байгуулсан сургалтын тоо	2 удаа	2 удаа	Байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг 4 зорилт 10 арга хэмжээний хүрээнд төлөвлөн хэрэгжилтийг хангаж ажилласан. Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Хар тамхитай тэмцэх газар, Орхон аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс хамтран зохион байгуулсан “Мансууруулах үйлчилгээтэй олсны ургамлыг устгах ажлын үр дүнг дээшлүүлэх нь” сэдэвт бүсчилсэн уулзалт, хэлэлцүүлэг бүхий хоёр өдрийн сургалтад Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, Хяналтын хэлтсийн Таримал ургамлын үр сортын хяналтын улсын байцаагч нар хамрагдсан. Хар тамхитай тэмцэх газраас зохион байгуулсан “АНЗААР” сэтгэцэд нөлөөлөх эм, мансууруулах бодисын хэрэглээнээс сэргийлэх сургалт, хэлэлцүүлэгт 3 албан хаагч танхимаар, бусад албан хаагч цахимаар хамрагдсан. Танилцуулга, гарын авлагын байгууллагын албан хаагчдад танилцуулж ажилласан. Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газартай хамтран Жендерийн талаарх мэдлэг ойлголт өгөх сургалтыг зохион байгуулж, 21 буюу нийт албан хаагчдын 92 хувийг хамруулсан.	100 Бүрэн хангалттай
1.2.	Зорилт 2. Төсөв, санхүү, эдийн засаг, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион	1. 841.6 Улсын төсөв 2. 271.1 Орон	1.Төсвийн зарцуулалт /сая.төг/	1.1,042,1 2. 100 хувь	1. 957.2 2. 100 хувь	1. 2025 онд нийт 957.2 сая төгрөг батлагдсанаас өссөн дүнгээр 11 дүгээр сарын 30-ны байдлаар 841.6 сая төгрөгийн санхүүжилт, гүйцэтгэл нь 832.5 сая төгрөг байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр гарган ХХААХҮЯамны Санхүү, хөрөнгө оруулалтын газарт	100 Бүрэн хангалттай

	байгуулан, ил тод байдлыг хангана. /Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, ТЖҮЧ 4.3., ЗДҮАХ 4.3./	нутгийн төсөв	2. https://shilendans.gov.mn/ сайтад мэдээллийг тайлагнах			хүргүүлсэн. Харилцагч байгууллага болон хувь хүнд үүссэн өглөг авлага байхгүй. 2.Төсвийн гүйцэтгэл болон хөрөнгө оруулалтыг тухай бүрд нь shilendans.gov.mn/сайтад мэдээлэн байгууллагын ил тод байдлыг ханган ажиллаж байна. Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой бүтэн жилд 159 мэдээлэл оруулах бөгөөд тайлант хугацаанд 141 мэдээлэл оруулахаас 141 мэдээллийг үнэн зөв, хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн.	
1.2.1	Арга хэмжээ 1. Байгууллагын төсөв, төлөвлөгөөг батлуулах, батлагдсан төсвийн санхүүжилтийг хугацаанд нь авах, тайлагнах.	1. 841.6 Улсын төсөв 2. 271.1 Орон нутгийн төсөв	1.Төсвийн зарцуулалт /сая.төг/ 2.Тайлагналтын хувь	1. 1,042.1 2. 100 хувь	1. 957.2 2. 100 хувь	1. 2025 онд нийт 957.2 сая төгрөг батлагдсанаас өссөн дүнгээр 11 дүгээр сарын 30-ны байдлаар 841.6 сая төгрөгийн санхүүжилт, гүйцэтгэл нь 832.5 сая төгрөг байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр гарган ХХААХҮЯмны Санхүү, хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн. Харилцагч байгууллага болон хувь хүнд үүссэн өглөг авлага байхгүй. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 176.1 сая төгрөгийн 50 ширхэг хүлэмж, Аймгийн өвс, тэжээлийн нөөцөд 95.0 сая төгрөгийн өвсийг хүлээн авсан. 2.2025 оны эхний хагас жилийн тайланг ХХААХҮЯмны Санхүү, хөрөнгө оруулалтын газарт албан бичгээр хүргүүлж, "Э-ТАЙЛАН" системд шивж илгээсэн, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн тайлагнах хугацаа 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болох тул хуулийн хугацаа хүлээгдэж байна.	100 Бүрэн хангалттай
1.2.2	Арга хэмжээ 2. Байгууллагын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн эзэмшил, хадгалалтын байдалд хяналт тавих, эд хөрөнгийн тооллого хийх.	-	Үндсэн хөрөнгийн тооллого хийсэн давтамж	2	2	Байгууллагын газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/21, 2025 оны 11 дүгээр сарын 17 ний өдрийн А/37 дугаар тушаалаар байгуулагдсан тооллогын комисс нь 2 удаагийн тооллогоор 907.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 5.1 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийг албан хаагчдын эд хөрөнгө ашиглалтын карттай тулган тоолсон. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ирсэн хөрөнгүүдийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг хянан, гэрээг сунган тооллогын ажлыг хийж гүйцэтгэсэн.	100 Бүрэн хангалттай

1.2.3	Арга хэмжээ 3. Шилэн данс shilendans.gov.mn-д мэдээлэл байршуулах.	-	Шилэн дансны ил тод байдлын хувь	98.1 хувь	100 хувь	Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой бүтэн жилд 159 мэдээлэл оруулна. Тайлант хугацаанд 141 мэдээлэл оруулахаас 141 мэдээллийг үнэн зөв, хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн.	100 Бүрэн хангалттай
1.3.	Зорилт 3. Салбарын хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, бодлогын баримт бичиг, хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж, эрсдэлийн удирдлагаар хангана. /Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаал, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан журам, ЗГҮАХ, Сайдтай байгуулсан 2025 оны гэрээ, ТЖҮЧ, ЗДҮАХ/	-	Хэрэгжилтийн хувь 1. Тогтоол шийдвэр 2. ЗГҮАХ 3. ХХААГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө	1. 100 хувь 2. 100 хувь 3. 99.7 хувь.	1. 100 хувь 2. 100 хувь 3. 100 хувь.	1. 100 хувь 2. Хугацаа болоогүй 3. 97.3	98.7 Бүрэн хангалттай
1.3.1	Арга хэмжээ 1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тооцож ажиллах	-	1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь 2. Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь	1. 99.7 хувь. 2. 100 хувь.	1. 100 хувь. 2. 100 хувь.	1. Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 7 стратеги зорилго, 17 зорилтын хүрээнд 65 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилт 82.2 хувь, жилийн эцсийн гүйцэтгэл 97.3 хувьтай биелсэн. 2. Аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд 7 хоног тутамд хяналт тавьж, 7 хоногийн мэдээнд тусган мэдээлж хэвшсэн. 2025 онд 42 үүрэг даалгавар ирснийг 100 хувь хэрэгжүүлэн хугацаанд нь тайлагнасан.	98.7 Бүрэн хангалттай
1.3.2	Арга хэмжээ 2. Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын	-	Хэрэгжилтийн хувь	1. 100 хувь 2. 100 хувь	1. 100 хувь 2. 100 хувь	1. Салбарын хэмжээнд мөрдөж байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сар бүр, хугацаанд нь тайланг илгээж, системд оруулсан. ХХААХҮЯ-ны Хяналт	100 Бүрэн хангалттай

	баримт хэрэгжилтийн нэгтгэж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.		1. Тогтоол шийдвэр 2. ЗГҮАХ			шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газарт Ерөнхий сайдын албан даалгаврыг 11 үзүүлэлтээр гаргаж хүргүүлж байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар хууль тогтоомжийн биелэлт 100%, Алсын хараа-2050 бодлогын баримт бичгийн хэрэгжилт 100%, Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийг мэдээллээр хангах журмын хэрэгжилт 100%, Орон нутгийн түвшинд үндэсний аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 100%, УИХ-ын 2022 оны 36-р тогтоолоор батлагдсан Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний биелэлт 92%, Шинэ хоршоо хөдөлгөөний тайлан 100%, Эрэгтэй эмэгтэй хүний дундаж насралтын зөрүүг багасгах талаар 2024-2027 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 100%, аймгийн ИТХ-аас гарсан тогтоол шийдвэр, Засаг даргын захирамжийн хэрэгжилт 99.5%, Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт хамтын хэлэлцээрийн хэрэгжилт 100%, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт 100%, Нээлттэй мэдээллийн тайлан 3 дугаар улирлын байдлаар дундаж биелэлт 87%, Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн салбарт мөрдөгдөж буй бодлогын баримт бичиг ЗДҮАХ-ийг 14 арга хэмжээ 100%, түүний шалгуур үзүүлэлт ТЕЗ-ийн 1, хөтөлбөрийн 9 үзүүлэлт 97.3%, Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 3 зорилт, 9 арга хэмжээ 97.4%, түүний шалгуур 2 зорилт 11 үзүүлэлт 80%, Орхон аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 19 арга хэмжээний 20 шалгуур үзүүлэлт 99.6%-тай хяналт шинжилгээ үнэлгээ хийж хугацаанд нь ХХААХҮЯ, ХШҮХ, ХЭЗХ, НБХ, БОНХОБТХ, Цахим хэлтэст тус тус тайлагнан ажилласан. 2. ЗГҮАХ-т хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр 4 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгагдсанаас хэрэгжилт хангалтгүй 2 ажил байна. Үүнд: Худаг шинээр гаргах болон агуулах саравч барих. Засгийн газрын 2025 оны 43 дугаар	
--	--	--	--------------------------------	--	--	---	--

						тогтоолын 3 дугаар хавсралтын 3.7.3 дахь заалтын дагуу хугацаа болоогүй гэж үнэлсэн.	
1.3.3	Арга хэмжээ 3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтэд урьдчилсан хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	-	Хэрэгжилтийн хувь	100 хувь	100 хувь	Сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилтэд 2025 оны эхний хагас жилийн байдлаар хяналт шинжилгээ үнэлгээг хийж, ХБТХОХ, ХШҮХ-т тус тус хүргүүлсэн. Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу үнэлэхэд 100% хэрэгжсэн. Хугацаа хүлээгдэж буй 16 арга хэмжээ буюу 43.2%, хэрэгжсэн үнэлгээтэй 21 буюу 56.8%-ийг тус тус эзэлж байна. Тус гэрээний ХБ үнэлэгдсэн 16 заалтыг Даргын зөвлөлийн хурлаар танилцуулж эрсдэлийн удирдлагаар хангаж ажилласан. 2025 оны жилийн эцсийн тайлан, 6 зорилт 37 арга хэмжээнд хяналт шинжилгээ үнэлгээг хийхэд 85 хувьтай хэрэгжсэн 1, 90-99 хувьтай хэрэгжсэн 4, 100 хувьтай хэрэгжсэн 32 заалт, гүйцэтгэлийн дундаж 98.7 хувьтай байна.	98.7 Бүрэн хангалттай
1.3.4	Арга хэмжээ 4. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол шийдвэрийн биелэлтэд урьдчилсан хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	-	Хэрэгжилтийн хувь	100 хувь	100 хувь	Аймгийн ИТХ-ын 5 тогтоол шийдвэрийг хяналтад авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд. 1. 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 19/03 дугаар тогтоолоор баталсан Орхон аймгийн 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын “Төлөвлөгөө батлах тухай” 2. 2023 оны 02 дугаар сарын 28-ны 14/02 дугаар тогтоолоор баталсан “Өрхийн болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих хөтөлбөр батлах тухай” 3. 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 12/02 дугаар тогтоолоор баталсан "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах" үндэсний хөдөлгөөний хүрээнд Орхон аймагт 2022-2027 онд хийгдэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” 4. 2025 оны ХАА-н өвөлжилт хаваржилтын 2025-2026 оны бэлтгэл хангах №03/33 тогтоолын хэрэгжилтийг Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын хяналт шинжилгээ үнэлгээний дүнгээр 100%-тай хэрэгжсэн.	100% Бүрэн хангалттай

						Аймгийн 2026 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө батлах тухай №03/46 тогтоолын хэрэгжилт хугацаа болоогүй байна.	
1.4.	Зорилт 4. Байгууллагын үйл ажиллагааны бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, засаглалын ардчилсан, нээлттэй, хүнд сурталгүй, ил тод, хариуцлагатай байдлыг идэвхжүүлэн, төрийн байгууллагын цахим мэдээллийн системийн гүйцэтгэлийг хангана. /Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Төрийн албаны ёс зүйн тухай хууль, Өргөдөл, гомдол шийдвэрлэх тухай хууль, ТЖҮЧ 4.3., ЗДҮАХ 4.3./	-	1.И-оффис систем ашиглалтын хувь 2.Шил ажиллагааны https://shilen.gov.mn сайтад мэдээллийг тайлагнах нээлттэй байдлын хувь	1. 100 хувь 2. 96 хувь	1.100 хувь 2. 100 хувь	1.100 2. 86.7	93.4 Бүрэн хангалттай
1.4.1	Арга хэмжээ 1. Аймгийн төрийн захиргааны байгууллагын нэгдсэн сүлжээ И-оффис системээр дамжуулан байгууллагын албан хэрэг хөтлөлтийг сайжруулах, мэдээлэх	-	И-оффис системийн ашиглалтын хувь	100 хувь	100 хувь	И-оффис системийн ашиглалтыг сайжруулах ажлын хүрээнд тайлан, дүн мэдээ, мэдээллийг түргэн шуурхай илгээх, хүлээж авах, солилцох, ирсэн баримт бичгийг цахимжуулах, бүртгэх шийдвэрлэлтэд хяналт тавих, албан хэрэг хөтлөлтийн шатанд хадгалах, ашиглах зэрэг цогц үйл ажиллагаагаар байгууллагын цахим мэдээллийн гүйцэтгэлийг ханган ажилласан. Системийн “Баримт бичиг төлөвлөх систем” талбарт гадагшаа явуулах бичиг, Газрын даргын тушаалууд шилжүүлж ажилласнаар тайлант хугацаанд “Бичиг төлөвлөлт хяналт” талбарт 524 албан бичиг идэвхтэй бүртгэгдсэн байна. Бодлогын баримт бичиг, Байгууллагын стратеги	100 Бүрэн хангалттай

						болон гүйцэтгэлийн төлөвлөгөө, нэгжийн төлөвлөгөө, төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон долоо хоногийн тайлан, төлөвлөгөө, бусад цэсийг бүрэн ашиглаж хэвшсэн.	
1.4.2	Арга хэмжээ 2. Байгууллагын цаасаар хадгалагдаж байгаа мэдээллийг цахимжуулах.	-	Цахимжуулсан мэдээллийн хувь	100 хувь	100 хувь	Байгууллагын цаасан суурьтай газрын даргын А тушаал 39, Б тушаал 46, нийт 85 тушаал, ирсэн 524 бичгээс хариутай 397, хугацаандаа яваа 17 бичиг, явсан бичиг 311, өргөдөл, гомдол, хүсэлт 123, байгууллагын шуурхай хуралдааны тэмдэглэлийг бүрэн цахимжуулан ажиллаж байна.	100 Бүрэн хангалттай
1.4.3	Арга хэмжээ 3. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, Шил ажиллагаа https://shilen.gov.mn/ сайтад мэдээллийг бүрэн мэдээлэх	-	Шил ажиллагааны нээлттэй байдлын хувь	96 хувь	100 хувь	Шил ажиллагааны https://shilen.gov.mn сайтад 5 бүлгийн 43 мэдээллийг хугацаанд нь тайлагнасан. 1 дүгээр улирлын тайлагналт 83 хувь, 2 дугаар улиралд 82.2 хувь, 3 дугаар улиралд 95 хувьтай тус тус үнэлэгдэж, дундаж үнэлгээ 86.7 хувьтай байна. 4 дүгээр улирлын тайлан 12 сарын 31-ний дотор тайлагнана.	86.7 Бүрэн хангалттай
1.4.4	Арга хэмжээ 4. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор байгууллагын албан хаагчдад зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах.	-	Зохион байгуулсан сургалтын тоо	2	2	Аймгийн ЗДТГазар, Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх мэдлэг олгох 2 удаагийн цахим сургалтад мэдүүлэг гаргагч болон төрийн захиргааны давхардсан тоогоор 22 албан хаагчийг хамруулан мэдлэг олгосон. Мөн аймгийн ЗДТГазрын Хууль эрх зүйн хэлтэстэй хамтран Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, анхаарах асуудал сэдвээр 1 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулж, нийт албан хаагчдын 93 хувийг хамруулан мэдлэг олгосон.	100 Бүрэн хангалттай
1.4.5	Арга хэмжээ 5. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд төлөвлөгөө гарган ажиллах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100 хувь	100 хувь	Байгууллагын ёс зүйн дэд хорооноос 2025 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд: 1. Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулсан, 2. Аймгийн ЗДТГазрын Хууль, эрх зүйн хэлтэстэй хамтран Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн мэдлэг олгох 1 удаагийн сургалт, 3. Ойн мандах Ёс зүйн академитай хамтран албан хаагчдад байгууллагын соёл, төрийн албан хаагчийн ёс	100 Бүрэн хангалттай

						зүйн тухай хууль, ёс зүйн хэм хэмжээ, харилцаа хандлага сэдвүүдээр 4 цагийн 1 удаагийн сургалт, 4. Ойн мандах Ёс зүйн академитай хамтран байгууллагын ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг чадавхжуулах 2 цагийн 1 удаагийн сургалт, 5. Албан хаагчдын дунд 7 хоногийн хугацаатай 1 удаагийн Талархлын аян, 6. Ойн мандах Ёс зүйн академитай хамтран албан хаагчдаас 1 удаагийн сэтгэл ханамжийн судалгаа, 7. Албан хаагчдын дунд хууль, эрх зүйн чиглэлээр танин мэдэхүйн АХА тэмцээнийг 1 удаа, 8. Албан хаагчдад хууль, эрх зүйн мэдлэг олгох чиглэлээр гарын авлага бэлтгэн хүргэх ажлыг 1 удаа, 9. Хүнс, хөдөө аж ахуйн газрын албан хаагчдын дотооддоо мөрдөн ажиллах ёс зүйн дүрмийг боловсруулан батлуулсан, 10. Байгууллагын ёс зүйн мэдээллийн самбарыг шинээр хийлгэн байршуулж, тухай бүр мэдээллийг шинэчлэн ажиллаж байна., 11. Ёс зүйн хорооны мэдээллийн нэгдсэн системд улирал бүр хийсэн ажлын тайланг гарган 4 удаа илгээг хэрэгжилт 100 хувь хангагдсан.	
1.5	Зорилт 5. Хүрээлэн байгаа орчны чанарыг дээшлүүлнэ. /Хог хаягдлын тухай хууль, Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, ЗГҮАХ 3.4.1.4., Ногоон хөгжлийн бодлого, Ногоон хөгжлийн шилжилт аймгийн стратеги төлөвлөгөө, ТЖҮЧ 6.1., ЗДҮАХ 3.6.1.1.,	1.7	1.Тарьсан модны тоо 2. Зохион байгуулсан ажлын тоо	1. 60 мод 2. 2 удаа	1. 50 мод 2. 5 удаа	1. 66 2. 6 удаа	100 Бүрэн хангалттай
1.5.1	Арга хэмжээ 1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэн мод	-	Тарьсан модны тоо	60	50	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Гурван замын уулзварын орчимд хаврын тарилтаар 120 ширхэг шар хуайс модыг 115,000 төгрөг тарьж, усалгаа,	100 Бүрэн хангалттай

	тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх.					арчилгаа хийсэн. Гадна талбай нийтийн эзэмшлийн газрын өнгө үзэмжийг сайжруулах ажлын хүрээнд Захиргааны 3 дугаар байранд үйл ажиллагаа явуулж байгаа 10 байгууллагын албан хаагчдыг зохион байгуулалтад оруулж, өөрсдийн дотоод нөөц боломжоор 1.7 сая төгрөгийн өртөг бүхий 880 ширхэг шар хуайс модыг тарьж, өдөр тутмын арчилгааг хийсэн. Намрын мод тарих өдрөөр нийт 66 бургас модыг 132.0 мянган төгрөгөөр албан хаагчдын санхүүжилтээр худалдан авч тарьсан. Нийт 3 удаагийн арга хэмжээгээр байгууллагын хэмжээнд 266 ширхэг мод, сөөгийг 293.0 мян.төгрөгөөр худалдан авч тарьж ургуулан 23 удаа усалж, тордсон. Ургалт 100%. Өмнөх жилүүдээс 4.4 дахин илүү мод сөөг тарьсан.	
1.5.2	Арга хэмжээ 2. Олон талын оролцоог хангасан хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөрт нэгдэх. Хог хаягдлыг ангилан ялгах зөв дадал хэвшүүлэх, 50м газраа хариуцан тогтмол цэвэрлэх	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2 удаа	5 удаа	Тайлант хугацаанд Аймгийн Засаг даргын үүрэг даалгавар болон байгууллагын гадна хуваарьт талбайн цас мөс, Баян-Өндөр сумын ЗДТГ-аас зохион байгуулсан хотын цэвэрлэгээний хүрээнд байгууллагын ойролцоох гуу жалга, Бурхантай уулын энгэрийн өнжмөл хогийг тус тус цэвэрлэсэн. Нийт 6 удаагийн арга хэмжээг зохион байгуулж ажилласан.	100 Бүрэн хангалттай
Стратеги төлөвлөгөөний зорилго 2. Мал аж ахуйн үйлдвэрлэл, малын генетик нөөцийн бодлого, стратегийн хэрэгжилтийг төлөвлөх, зохион байгуулах, зохицуулах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, эрчимжүүлэх, бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, усан хангамжийг сайжруулах, малыг байгаль, цаг агаарын эрсдэлээс хамгаалах, тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх, малчны орлого нэмэгдүүлэх, генетик нөөцийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, баяжуулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах.							
2.1.	Зорилт 1. Эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжинэ. /Алсын хараа 2021-2030 БББ8.3.5., ХХААХҮ-ийн сайдтай байгуулсан 2025	-	1.Сургалт, үйл ажиллагаанд хамрагдсан малчдын тоо 2.Дэмжлэг /сая.төг/	1. 90 малчин хамрагдсан. 2. 797.5	1. 25 малчин 2. 500.0	1. 48 малчин 2. 3 иргэн, 4 хоршоо, 2 аж ахуйн нэгж нийт 694.0 сая.төг	Бүрэн хангалттай

	оны гэрээ 1.5, ТЖҮЧ 8.5.4., ЗДҮАХ 3.5.2.2./						
2.1.1	Арга хэмжээ 1. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг чадавхжуулах сургалтад хамруулах, туршлага судлах арга хэмжээг зохион байгуулах.	-	Хамрагдсан малчдын тоо	90	2 удаагийн сургалтад 25 малчин	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 15 иргэнд Баян-Өндөр, Жаргалант сумдын ЗДТГ-ын Хөдөө аж ахуйн тасагтай хамтран Малын үржил селекц, зохистой дадлын талаар сургалт зохион байгуулсан. Зөгий, тахиа, гахай зэрэг туслах аж ахуй эрхлэгч 18 иргэнд эрчимжсэн аж ахуйн бодлого, цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар, сургалт зохион байгуулсан. Тус 2 удаагийн сургалтаар ЖДҮХС-ийн зээл, Шинэ хоршоо хөдөлгөөн, Атар IV аяны зээлийн мэдээллүүдийг танилцуулан мэргэжил арга зүйн зөвлөмж, зөвлөгөө өгч ажилласан. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор 15 фермер эрхлэгч нарыг 2025 оны 10 дугаар сард Сэлэнгэ аймгийн Мандал сумын сүүний үхрийн аж ахуй, Төв аймгийн Баянхангай сумын Харамафүжи сүүний үхрийн аж ахуй, Түмэн шувуут тэжээлийн үйлдвэр, Ар гүнт малчид хоршооны үйл ажиллагаатай танилцуулан, туршлага судлуулж ажилласан.	Бүрэн хангалттай
2.1.2	Арга хэмжээ 2. Эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх ажлыг өргөжүүлэн, фермерүүдийг дэмжих.	-	Зээл олголтын хэмжээ /сая.төг/	797.5	500.0	2025 оны эхэнд аймгийн хэмжээнд 175.8 мянган толгой мал тоологдож, 101 иргэн эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байна. Үүнд: 23 иргэн мах-сүүний чиглэлийн 714 толгой үхэр, 7 иргэн махны чиглэлийн 421 толгой үхэр, 4 иргэн 130 толгой гахай, 55 иргэн 4344 толгой шувуу, 12 иргэн 242 бүл зөгийг өсгөн үржүүлж байна. Монгол Улсын Засгийн газрын 47 дугаар тогтоолоор батлагдсан “Атар-4” тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хүрээнд: -Сүүний чиглэлийн үхэр худалдан авахаар 2 иргэнд 100.0 сая төгрөг, -Тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд САМБО ШИМТ сүрэг ХХК аж ахуйн нэгжид 50.0 сая төгрөг, Аймгийн Өрхийн болон бичил, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих сангаас: -Тахианы аж ахуй эрхлэгч 1 иргэнд 100.0 сая төгрөг,	Бүрэн хангалттай

						ЖДҮХСангаас: -“Хөгжилтэй зөгий” нөхөрлөлд 100.0 сая төгрөг, Баян-Өндөр, Жаргалант сумдын Хоршоо хөгжүүлэх сангаас: -4 хоршоонд 344.0 сая төгрөг, нийт 9 иргэн, аж ахуй нэгжийг 694.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамруулсан.	
2.2.	Зорилт 2. Малын үүлдэр угсаа чанарыг сайжруулж, тооноос чанарт шилжинэ. /Алсын хараа 2021-2030 БББ 8.3.15., 8.3.16., ЗГҮАХ 3.3.4.11, ХХААХҮ-ийн сайдтай байгуулсан 2025 оны гэрээ 1.4, ТЖҮЧ 8.5.3., ЗДҮАХ 3.5.2.2./	-	Үзлэг ангилалтад хамрагдсан малын тоо	40000	41200	Аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 174 малчин өрхийн 41.2 мянган толгой малыг үзлэг ангилалт, хянан баталгаажуулалтад хамруулан ажилласан. Үүнд: Үхэр-8690, хонь- 17894, ямаа-14616 Мал сүрэгт үзлэг ангилалт хийж малын үүлдэр угсаа, ашиг шим, анги чанарыг тодорхойлсны үр дүнд: Нийт үхэр сүргийн 30 хувь буюу 10.4 мянган толгой үхэр нь Герефорд, Сэлэнгэ үүлдрийн үндсэн хэв шинжийг хадгалсан байна. Мөн хонин сүргийн 24.3 хувь буюу 15.5 мянган толгой хонь Барга үүлдрийн хэв шинжийг хадгалснаар махны гарц 1.5-2.0 кг-аар нэмэгдсэн байна.	100 Бүрэн хангалттай
2.2.1	Арга хэмжээ 1. Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид ялган төвлөрүүлэх. Бог малын өсвөр хээлтүүлэгчийг нөхөн тавих.	-	Ялган төвлөрүүлсэн хээлтүүлэгчийн хувь Нөхөн тавьсан хээлтүүлэгчийн тоо	1. 81.2 хувь 2. 40 толгой	1. 80 хувь 2. 50 толгой	1. 2025 оны эхэнд бог малын 719 толгой хээлтүүлэгч мал тоологдсоноос 80.5 хувь буюу 579 толгой хээлтүүлэгчийг 3 суурьт ялган төвлөрүүлэн мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжийн хяналтад авч мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. 2. Мөн малчид үзлэг ангилалт, хянан баталгаажуулалтад хамруулсан цөм сүргийн малаас 50 толгой бог малын өсвөр хээлтүүлэгчийг шинээр нөхөн тавьсан.	100 Бүрэн хангалттай
2.2.2	Арга хэмжээ 2. Мал сүрэгт үзлэг ангилалт хийж, анги чанарыг тодорхойлох	4.3 Орон нутгийн төсөв	Үзлэг ангилалтад хамрагдсан малын тоо	40000	41200	Аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 174 малчин өрхийн 41200 толгой малыг үзлэг ангилалт, хянан баталгаажуулалтад хамруулахад 8266 толгой буюу 20.1 хувь нь цөм сүрэг, 29954 толгой буюу 72.7 хувь үржлийн сүрэг, 2980 толгой буюу 7.2 хувь нь хэрэгцээний сүрэгт бүртгэгдэж анги чанарыг тодорхойлон ажилласан. Үүнд: Үхэр-8690, хонь- 17894, ямаа-14616 толгой. Мөн үзлэг ангилалтад хамрагдсан үхэр, хонь, ямааны 10 хувьд нь хяналтын хэмжилт хийсэн.	100 Бүрэн хангалттай

2.3.	Зорилт 3. Бэлчээрийн даац болон усан хангамжийг сайжруулах. /Алсын хараа 2021-2030 БББ 6.2.12., ЗГҮАХ 3.3.4.21., ХХААХҮ-ийн сайдтай байгуулсан 2025 оны гэрээ 1.2, 3, ТЖҮЧ 8.5.3., ЗДҮАХ 3.5.2.2./	11.8 Баян-Өндөр сумын төсөв	-Бэлчээрийн усан хангамжийн хувь, -Бэлчээрийн даац, хүрэлцээ хангамж тодорхойлсон цэгийн тоо	1. 87 хувь 2. 7 цэг	1. 87 хувь 2. 9 цэг	1. 87% 2. 9 цэг	100 Бүрэн хангалттай
2.3.1	Арга хэмжээ 1. Худаг, уст цэгийг сэргээн засварлаж, байршил зүйн зураглал гаргах.	-	Сэргээн засварласан худгийн тоо	1	1-2	Аймгийн хэмжээнд бэлчээрийн зориулалттай 87 худаг, уст цэг байгаагаас инженерийн хийцтэй худаг 82, энгийн уурхайн худаг 5 байна. Үүнд: Ашиглахад бэлэн 85 худаг байна. Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Баян-Өндөр сумын Шанд, Гээг, Зүйлийн хөндийн бэлчээрийн 3 худгийг 11.8 сая төгрөгөөр сэргээн засварласан. Үүний үр дүнд 42 өрхийн 5300 толгой мал усаар хангагдсан.	100 Бүрэн хангалттай
2.3.2	Арга хэмжээ 2. Бэлчээрийн хүрэлцээ хангамж, даац тодорхойлох.	-	Бэлчээрийн даац, хүрэлцээ хангамж тодорхойлсон цэгийн тоо	Бэлчээрийн 39.3 га талбайтай. Нийт бэлчээрийн 7 цэгт даац тодорхойлсон.	Нийт 9 цэгээс тодорхойлно	Орхон аймаг нь 38.3 мянган га бэлчээрийн талбайтай. УЦУОШТ-тэй хамтран 2025 оны 08 дугаар сарын 14-17-ны хооронд Баян-Өндөр, Жаргалант сумдын бэлчээрийн талбайн 9 цэгээс 36 дээж авч ургамлын ургацыг тодорхойлон ажилласан. Бэлчээрт 105 төрөл зүйлийн өвслөг ургамал зонхилж, ургамлын бүрхэвч сийрэг, өндөр 6-11см, бэлчээрийн 1га талбайн дундаж ургац нь 4.4 цн/га байна. Өмнөх оноос бэлчээрийн 1 га талбайн ургац 3.9 цн -ээр бага байна. Бэлчээрийн даацыг тооцоолж үзэхэд нийт нутгийн • 14.5 % - бэлчээр хүрэлцээтэй • 30.4 % - даац 1-3 дахин хэтэрсэн • 29.9 % -даац 3-5 дахин хэтэрсэн • 25.2% - даац олон дахин хэтэрсэн байна.	100 Бүрэн хангалттай
2.4.	Зорилт 4. Мал аж ахуйг байгаль, цаг уурын эрсдэлээс хамгаалах, бэлэн байдлыг	-	Өвс, тэжээл аюулгүйн нөөц бүрдүүлэлтийн хувь	100 хувь 480.5 тн	100 хувь 480 тн	1. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 56 дугаар тогтоолын дагуу аймаг, сумдын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг 100 хувь бүрдүүлэн ажилласан.	100 Бүрэн хангалттай

	хангах, сумдад өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх, тэжээлийн үйлдвэрлэл нэмэгдүүлнэ. /Алсын хараа 2021-2030 БББ 2.5.16., 8.3.4. ЗГҮАХ 3.4.2.6., 3.3.4.9, ХХААХҮ-ийн сайдтай байгуулсан 2025 оны гэрээ 1.1, ТЖҮЧ 8.5.3., ЗДҮАХ 3.5.2.2./		Тэжээл үйлдвэрлэлт /тн/			2.Малчид өөрсдийн нөөц бололцоогоор 607.1 тн үйлдвэрийн тэжээл бэлтгэсэн. Тэжээл үйлдвэрлэлийн хэмжээг өмнөх оноос 15.0 хувиар нэмэгдүүлсэн.	
2.4.1	Арга хэмжээ 1. Аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх.	-	Засгийн газрын тогтоолоор тогтоосон хэмжээний хувь	100 хувь	100 хувь	МУ-ын Засгийн газрын 2025 оны 56 дугаар тогтоолоор аймаг, сумдын аюулгүйн нөөцөд нийт 166 тн бүдүүн тэжээл (өвс), 144 тн хүчит тэжээл бэлтгэхээс 190 тн өвс, 112.5 тн үйлдвэрийн тэжээлийг бэлтгэсэн. Үүнд: • Аймгийн аюулгүйн нөөцөд: Өвс 60 тн, тэжээл 42.5 тн • Баян-Өндөр сум: Өвс 80 тн, тэжээл 40 тн • Жаргалант сум: Өвс 50 тн, тэжээл 30 тн	100 Бүрэн хангалттай
2.4.2	Арга хэмжээ 2. Малчдын түвшинд байгалийн хадлан бэлтгэх, тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.	-	1. Бэлтгэсэн байгалийн хадлан, /тн/ 2. Үйлдвэрийн тэжээл /тн/	1. 11722 2. 480.5	1. 11800 2. 480	1. Малчдын түвшинд 17500 тн байгалийн хадлан бэлтгэхээс 17854 тн байгалийн хадлан, 163 тн сүрэл, 923 тн ногоон тэжээл, 607.1 тн үйлдвэрийн тэжээл, 105 тн гар тэжээл, 269 тн дарш ногооны хаягдал, 460 тн давс, хужир, шүү бэлтгэсэн. 2. Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал аж ахуй биотехнологийн сургуультай хамтран малчдын түвшинд тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор 112 малчин өрхөд "Өвөлжөө, хаваржааны бууцны хөл газар"-т тэжээл тариалах сургалтыг зохион байгуулж 100 сая төгрөгийн олон наст тэжээлийн ургамлын үрийг олгосон. Үүний үр дүнд: 78 га талбайд тэжээлийн ургамал тариалж, 220 тн тэжээл хураан авч тэжээл үйлдвэрлэлийн хэмжээг өмнөх оноос 15.0 хувиар нэмэгдүүлсэн.	100 Бүрэн хангалттай
2.4.3	Арга хэмжээ 3.	-	Малаа даатгуулсан	18	25	Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийг 370 малчдад сурталчлан гарын авлага, заавар зөвлөмж өгч мэдээллээр ханган ажилласан. 2025 онд Баян-Өндөр,	100 Бүрэн хангалттай

	Малын даатгалын хуулийн хэрэгжилтийг хангуулах ажил зохион байгуулах		малчин өрхийн тоо			Жаргалант сумын 26 малчин өрхийн 2775 толгой малыг 145.6 сая төгрөгийн даатгалд хамруулсан байна.	
2.5.	Зорилт 5. Малчдыг мэдээллээр хангаж, орон нутагтаа ая тухтай ажиллаж, амьдрах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. /Алсын хараа 2021-2030 БББ 8.3.10., 8.3.16., ЗГҮАХ 3.3.4.29., 3.4.2.6., ХХААХҮ-ийн сайдтай байгуулсан 2025 оны гэрээ 1.7, ТЖҮЧ 8.5.3., ЗДҮАХ 3.5.2.2./	4.2 Орон нутгийн төсөв	Төрийн үйлчилгээ хүргэсэн малчин, мал бүхий иргэдийн тоо	1303	620	843	100 Бүрэн хангалттай
2.5.1	Арга хэмжээ 1. Үржлийн стандартын шаардлага хангасан хээлтэгч, хээлтүүлэгчээр малчин мал бүхий иргэдийг хангах	-	Үржлийн шаардлага хангасан хээтүүлэгч авсан малчдын тоо	40	50	2022-2025 онуудад Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Барга үүлдрийн хуц 60 толгой, Эрчмийн хар үүлдрийн ухна 40 толгой, Герефорд үүлдрийн бух 15 толгой нийт 115 толгой өсвөр хээлтүүлэгчийн худалдан авч малчдад түрээсээр ашиглуулж байна. Үржлийн стандартын шаардлага хангасан 63 толгой хээлтүүлэгчийг 2025 оны 10 дугаар сард 51 малчин өрхөд түрээсийн гэрээ байгуулан олгосон. Үүнд: бух-15, хуц-34, ухна-14.	100 Бүрэн хангалттай
2.5.2	Арга хэмжээ 2. Малчдад төрийн үйлчилгээг хүргэх.	-	Малчин, мал бүхий иргэдэд үйлчилгээ үзүүлсэн давтамж	2 удаа	2 удаа	Монгол улсын Засгийн газрын 2025 оны 56 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 03/33 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын А/170 дугаар захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын цаг үеийн нөхцөл байдалтай танилцахаар 2025 оны 01, 03, 09 дүгээр саруудад Хүнс, хөдөө аж ахуйн газар, 2 сумын Засаг даргын тамгын газар, Мал эмнэлгийн газар, Эрүүл мэндийн газар, Нийгмийн даатгалын газартай хамтран Баян-Өндөр, Жаргалант сумдын 10-12 чиглэлд	100 Бүрэн хангалттай

						давхардсан тоогоор 843 малчин өрхөөр орж төрийн үйлчилгээ үзүүлэн ажилласан.	
2.5.3	Арга хэмжээ 3. Малчдад гамшгаас хамгаалах сургалт сурталчилгааг зохион байгуулах	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	1-2	Малчдад гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, бэлтгэсэн өвс, тэжээлийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор ОБГ-ын Гал түймрийн Улсын хяналтын байцаагчтай хамтран галын аюулгүйн байдлын зөвлөмж боловсруулан Баян-Өндөр, Жаргалант сумдын 85 малчин өрхөд 2 удаагийн мэдээлэл өгч, ХХААГ-ын пэйж хуудсаар видео шторк бэлтгэн иргэд, малчдад мэдээлэл хүргэж ажилласан.	100 Бүрэн хангалттай
Стратеги төлөвлөгөөний зорилго 3. Газар тариалангийн үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах үндсэн үүрэг хүлээж, тариалангийн үйлдвэрлэлийн байгаль, цаг агаарын эрсдэл даах чадавхыг нэмэгдүүлж уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, үр, сортын шинэчлэл, хөрсний үржил шимийг сайжруулах, хамгаалах, таримал ургамлын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн тогтвортой, хүртээмжтэй хангамжийг бий болгох тариалангийн үйлдвэрлэлд байгаль орчинд ээлтэй техник, технологи нэвтрүүлэн тогтвортой хөгжлийг хангах, эрчимжүүлэн хөгжүүлнэ.							
3.1.	Зорилт 1. Тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, газар тариалангийн хүрсэн түвшинг тогтворжуулан хөгжүүлнэ. /Алсын хараа 2021-2030 БББ 8.3.22, ЗГҮАХ 3.3.4.13, 3.4.2.3., ХХААХҮ-ийн сайдтай байгуулсан 2025 оны гэрээний 2 дугаар бүлэг, ТЖҮЧ 8.5.2., ЗДҮАХ 3.5.2.2./	0.77 Орон нутгийн төсөв	1.Тариалсан талбай га, 1.1 Үр тариа 1.2 Малын тэжээл 1.3 Тосны ургамал 1.4 Төмс 1.5 Хүнсний ногоо 1.6 Жимс жимсгэнэ 2. Хураан авсан ургацын хэмжээ тн 2.1 Үр тариа 2.2 Малын тэжээл 2.3 Тосны ургамал 2.4 Төмс	1.1 3841 1.2 280 1.3 832 1.4 167 1.5 474 1.6 1.3 нийт 5594 га. 2.1 10097 2.2 1294 2.3 284 2.4 1941 2.5 12149 2.6 42.9	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайд, аймгийн Засаг даргатай 2025 онд байгуулсан гэрээний хэрэгжилтийг ханган хүрсэн түвшинг тогтворжуулна	Аймгийн хэмжээнд газар тариалангийн салбарт 13 аж ахуйн нэгж, байгууллага, 272 өрх үйл ажиллагаа явуулж 5691 га талбайд тариалалт хийж, ургац хураалт 100 хувьтай байна. 1. 3719 га-аас 10850 тонн буюу 30.0 цн/га үр тариа , 2. 598 га-аас 1007 тонн буюу 20 цн/га тэжээлийн ургамал 3. 746 га-аас 750 тонн буюу 10 цн/га тосны ургамал 4. 165.1 га-аас 1959 тонн буюу 118 цн/га төмс, 5. 463 га-аас 11894 тонн буюу 260 цн/га хүнсний ногоо 6. Жимс, жимсгэнэ 50.3 га талбайд хураалт хийж 69 тн ургац тус тус хураасан. 2025 оны ургацаар тооцоход аймгийн хүн амын хэрэгцээт улаан буудай 100 хувь, хүнсний ногоо 100 хувь, төмс 52 хувь орон нутгийн үйлдвэрлэлээр хангаж байна. Төмсний хангамж 11.5 хувиар нэмэгдсэн байна.	71.6 Хангалттай

			2.5 Хүнсний ногоо 2.6Жимс жимсгэнэ				
3.1.1	Арга хэмжээ 1. Өрхийн тариалалтыг дэмжих хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх.	250.0 Орон нутгийн төсөв	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	98 хувь	100 хувь	Өрхийн тариалалтыг дэмжих зорилгоор 2025 онд өрхийн тариалалтыг дэмжих хөтөлбөрийн төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар 9 арга хэмжээ төлөвлөн батлуулж, хэрэгжилтийн дундаж 98.1 хувьтай байна.	98.1 Бүрэн хангалттай
3.1.2	Арга хэмжээ 2. Тариалангийн талбайд ойн зурвас байгуулах	-	Ойн зурвас байгуулсан хэмжээ /м/	300 м	300м	Тариалангийн талбайн хөрс хамгаалах арга хэмжээний хүрээнд төмөр бетон шонг тариаланчдын эзэмшилд шилжүүлж, ашиглалтын гэрээг 9 аж ахуйн нэгж 3 иргэнтэй байгуулсан. Үүний үр дүнд нийт 4100 га талбайг хашиж хамгаалан ойн зурвас байгуулах нөхцөл бүрдсэн. Гэрээний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Талын нуур ХХК, Хангарьд Ажнай ХХК нь 30 гаруй мянган ширхэг улиасны суулгац үржүүлж, өөрийн эзэмшлийн тариалангийн зориулалттай талбайд хамгаалалтын зурвас байгуулахаар бэлтгэл ханган ажилласан. Энэ нь 12.5 км зурвас байгуулах хэмжээ буюу нийт тариалангийн талбайг хамгаалахад 17.8 хувьтай тэнцэх хэмжээ.	30 Хангалтгүй
3.1.3	Арга хэмжээ 3. Төмс, хүнсний ногооны усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлэх, техник технологийн шинэчлэлт хийх	-	Усалгаатай талбайн хэмжээ га	16 га	Талбайн хэмжээг нэмэгдүүлс эн байна.	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны хэрэгжүүлж буй “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” төслийн хүрээнд услалтын системийг шинэчлэн сайжруулах төслийн 2 дугаар шатанд Хангал голын дагуу төмс, хүнсний ногооны 700 га талбайн усалгааны нөхцөл сайжруулахаар шийдвэрлэсэн. Тус ажлын даалгаврын төслийг боловсруулах Ажлын хэсэгтэй хамтран Жаргалант сумын төсөл хэрэгжүүлэх газар дээр нь ажиллаж, холбогдох албан тушаалтантай уулзан санал солилцож, шаардлагатай судалгаа, мэдээллээр ханган ажилласан. Төслийн ажлын даалгавар, зураг төсөв боловсруулах ажил хийгдэж байна. Аймгийн хэмжээнд усалгаатай нөхцөлд төмс 165 га, хүнсний ногоо 463 га талбайд тариалж 1959 тн төмс,	30 Хангалтгүй

						11894 тн хүнсний ногоо хураан авсан. Усалгаатай талбайн 10 га инженерийн хийцтэй, 16 га талбай 1 га услах хүчин чадалтай бороожуулах системээр, 602 га гадаргуугийн буюу нийт усалгаатай талбайн 4.1 хувь услалтын систем, 95.9 хувийг гадаргуугийн усалгааны аргыг хэрэглэж байна.	
3.1.4	Арга хэмжээ 4. Үрийн тариалангийн талбайд сортын хянан баталгаа хийх, хаврын тариалалтад шаардлагатай улаан буудайн үрийн нөөц бүрдүүлэх	-	Стандартын шаардлага хангасан нөөцөлсөн үрийн хэмжээ /тн/	5558 тн	Үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.	Үр тариа сортын үрийн хянан баталгааг хийж гүйцэтгэсэн. Хянан баталгаанд үр тарианы үйлдвэрлэл эрхлэгч 4 аж ахуйн нэгжийн 1951 га талбайд тариалсан 5 сортын улаан буудайг хамруулсан. Үүнд Гонец, Байкальская, Бурятская остистая, Алтайская-70, Алтайская-325 сортуудад хянан баталгаа хийж гүйцэтгэсэн. Аймгийн хэмжээнд нийт 3719 га талбайд улаан буудай тариалж 10554 тонн буюу 27 цн/га улаан буудай хураан авсан. Улаан буудай борлуулалт: • Өөрийн үрд 805 тн • Гурилын үйлдвэрт 4280 тн • Улсын үрийн нөөцөд 4800 тн • Спиртийн үйлдвэрт 640 тн борлуулсан. Стандартын шаардлага хангасан 5605 тн үр бэлтгэсэн.	100 Бүрэн хангалттай
3.1.5	Арга хэмжээ 5. Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх, хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх.	200.0 Орон нутгийн төсвөөс	Хамгаалагдсан хөрсний тариалалт, хураан авсан ургацын хэмжээ /га, тн/	Нийт 273 иргэн, 4 аж ахуйн нэгж 30.3 мянган.м.к в хүлэмжийн талбайгаас 332 тн ургац авсан.	Хамгаалагдсан хөрсний тариалалт, хураан авсан ургацын хэмжээг нэмэгдүүлсэн байна.	Хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн төсвийн 200.0 сая төгрөгийн 6*10 м-ийн харьцаатай 50 ширхэг хүлэмж худалдан авч олгох ажлыг зохион байгуулан Жаргалант суманд 29, Баян-Өндөр сумын 21 иргэнд олгосон. Үүний үр дүнд хүлэмжийн талбай 3000 м.кв нэмэгдэх боломж бүрдсэн. Аймгийн хэмжээнд нийт 223 иргэн, 6 аж ахуйн нэгж 37.8 мян.м.кв хүлэмжийн талбайд тариалалт эрхэлж 439.6 тн ургац хураан авсан нь хүнсний ногооны нийт ургацад хамгаалагдсан хөрсний ургац 4 хувьтай байна. Хүлэмжийн аж ахуй эрхлэгч 2 аж ахуйн нэгж, 1 иргэний 1450 м.кв бүхий 3 ширхэг нарлаг хүлэмжид 8.6 сая төгрөгийн цахилгааны хөнгөлөлт үзүүлсэн.	100 Бүрэн хангалттай
Стратеги төлөвлөгөөний зорилго 4. Хүнсний үйлдвэрлэл, хангамж, худалдааны бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах үндсэн үүрэг хүлээж, хүнс, хоол үйлдвэрлэлд үнэ цэний болон кластерийн сүлжээг хөгжүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, импортыг орлох, экспортын боломжийг							

нэмэгдүүлэх, аймгийн хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, стратегийн хүнсний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах, хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэх, бэхжүүлэх, мэдээллийн цахим санд мэдээлэх, хэрэгжилтийг хангах.							
4.1	Зорилт 1. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг орон нутгийн үйлдвэрлэлээр хангана. /Алсын хараа 2021-2030 БББ 8.3.34., 8.3.35., 8.3.36., ЗГҮАХ 3.3.4.2., ХХААХҮ-ийн сайдтай байгуулсан 2025 оны гэрээний 3 дугаар бүлэг, ТЖҮЧ 8.5.1., ЗДҮАХ 3.5.1.1./	-	Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хангамжийн хувь	Малын мах 70, сүүний 7.8, цагаан идээ 6, гурил 3, гурилан бүтээгдэхүүн 54.5, төмсний 51.6, хүнсний ногоо 100 хувь	Хүнсний хангамжийн дотоодын үйлдвэрлэлийн хувь, хэмжээг нэмэгдүүлсэн байна.	Аймгийн хэмжээнд хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр 80 гаруй үйлдвэр, цех үйл ажиллагаа явуулж, оны эхний 10 сарын статистик мэдээгээр 8 нэрийн 02 төрлийн 34.1 тэрбум төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 40.1 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна. Үүнээс 7 төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 13.8-41.9 хувиар буурч, 8 төрлийн бүтээгдэхүүн 10.7-66.1 хувиар, адууны мах, ямааны мах, тараг зэрэг 3 төрлийн бүтээгдэхүүн 6-11 дахин үйлдвэрлэл тус тус өссөн үзүүлэлттэй. Төмс 188.5 га, хүнсний ногоо 470.2 га талбайд тариалалт хийж, төмс 2275.5 тн, хүнсний ногоо 11585.1 тн-ыг тус тус хураан авсан. Үүний дүнд аймгийн хүн амын физиологийн хэрэгцээт махны 67.5 хувь, сүүний 11.4 хувь, цагаан идээний 4.7 хувь, гурилан бүтээгдэхүүний 39.6 хувь, төмсний 60.4 хувь, хүнсний ногооны 100 хувь, өндөгний 8.1 хувийг дотоодын үйлдвэрлэлээс хангаж байна.	100 Бүрэн хангалттай
4.1.1.	Арга хэмжээ 1. Хаврын улирлын махны нөөц бүрдүүлэх	400.0 Орон нутгийн төсөв	Хаврын хэрэгцээт махны хангалтын хувь хэмжээ	21.6 хувь буюу 200 тн	20 хүртэл хувь	Аймгийн хүн амын 2025 оны хаврын махны хэрэгцээнд эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагад нийцсэн үйлдвэрийн аргаар бэлтгэсэн үхэр, хонь, ямааны 200 тн мах бэлтгэж, 3 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн Баян-Өндөр сумын 29 цэгт, Жаргалант суманд 3 цэгт үхрийн мах 1 кг нь 12300, хонины мах 1 кг нь 10300, ямааны мах 1 кг нь 8300 төгрөгийн үнээр хэрэглэгчдэд хүргэсэн. Энэ нь хаврын хэрэгцээт махны 21.5 хувийг хангасан. Нөөцийн махыг бэлтгэн, нөөцөлж, худалдан борлуулах сонгон шалгаруулалтад 3 аж ахуйн нэгж оролцсоноос Эрдмийт ХХК шалгарч, гэрээний үүргээ 100 хувь биелүүлэн ажилласан. Зах зээлийн үнээс үхрийн мах 1 кг нь 6200, хонины мах 1 кг нь 4867, ямааны мах 1 кг нь 3700 төгрөгөөр тус тус хямд нийлүүлэгдэж, Үхрийн мах 682.0 сая төгрөг, хонины мах 389.4 сая төгрөг, ямааны мах 37.0 сая төгрөг, нийт 1,1 тэрбум төгрөгийн дэмжлэгийг иргэдэд хүргэсэн байна.	100 Бүрэн хангалттай

4.1.2.	Арга хэмжээ 2. Орон нутгийн үйлдвэрлэгчдийн бараа, бүтээгдэхүүнийг олон нийтэд таниулан сурталчлах, борлуулалтыг дэмжих үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, гадаад дотоодын үзэсгэлэнд бизнес эрхлэгчдийг дэмжин оролцуулах	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2	2	-Хойд бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдааны хүрээнд Булган аймагт “Түншлэл-Хамтын ажиллагаа” үзэсгэлэн зохион байгуулагдаж, Орхон аймгаас 8 хүнсний үйлдвэрлэгчийг оролцуулсан. -Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулга” хэлэлцүүлэг зохион байгуулсантай холбогдуулан хүнсний үйлдвэрлэл эрхлэгч 20 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан. -Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас зохион байгуулсан “Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл-2025” нэгдсэн арга хэмжээнд 13 аж ахуйн нэгж 2 иргэн оролцож “Шилдэг ногоочин”-оор Жаргалант сумын ногоочин Б.Жаргал шалгарсан. Үзэсгэлэн арга хэмжээнд орон нутгаа сурталчлан оролцож бараа бүтээгдэхүүнээ худалдаалан 101.9 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. Орон нутгаас оролцсон иргэн, аж ахуйн нэгжид шатахууны дэмжлэг олгон, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчлан, хаяг, анонс бэлтгэн хэвлүүлж, дэмжин ажилласан.	100 Бүрэн хангалттай
4.1.3.	Арга хэмжээ 3. Орон нутгийн хүнсний бүтээгдэхүүнийг хөгжүүлэх зорилгоор болзолт уралдаан зарлаж, бүтээгдэхүүн хөгжүүлэлтэд дэмжлэг үзүүлэх	14.3 Орон нутгийн төсөв	Дэмжлэгт хамрагдсан үйлдвэрийн тоо	-	3	Хойд бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдааны хүрээнд бүсийн хэмжээнд бараа бүтээгдэхүүнээ сурталчлан таниулах ажил зохион байгуулагдаж бүсийн брэнд бүтээгдэхүүн шалгаруулах уралдаанд Эрдэнэт хивс ХХК-ний хивсэн бүтээгдэхүүн, Эрдмин ХХК-ний цахилгааны уртасгагч, Орда заан хошуу ХХК-ний сүүт нэрийн бүтээгдэхүүн, Баярмөнх наран ХХК-ний Хүндэтгэлийн багц, Өндөрлөг урлан цехийн арьсан цүнх гэсэн 5 бүтээгдэхүүнийг нэр дэвшүүлэн холбогдох материалыг Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнд хүргүүлэн ажилласан. Аймгийн Засаг даргын 2025 оны А/955 дугаар захирамжаар Орон нутгийн хүнсний бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, сурталчлан таниулах өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулж, орон нутгийн брэнд бүтээгдэхүүний үзэсгэлэн, амталгаат худалдаа, бүтээгдэхүүний чанар,	100 Бүрэн хангалттай

						сав, баглаа боодол, шошгын стандартын хэрэгжилтийг үнэлэх, телевиз сошиал орчинд мэдээлэл түгээх, шилдэг 3 үйлдвэрлэгчийг шалгаруулан өргөмжлөлөөр шагнаан урамшуулсан. Тус арга хэмжээнд орон нутгийн төсвөөс 14,250,000 төгрөг зарцуулсан.	
4.1.4.	Арга хэмжээ 4. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн ур чадварыг дээшлүүлэх, ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулах, улс, бүсийн арга хэмжээнд дэмжин оролцуулах, чадавхжуулах сургалт зохион байгуулах	7.0	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	3	2-оос доошгүй	Аймгийн Засаг даргын 2025 оны А/423 дугаар захирамжаар Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн ур чадварыг дээшлүүлэхэд 7.0 сая төгрөгөөр дэмжиж ажилласан. 2025 сарын 03 сарын 28-ны өдөр Хоол үйлдвэрлэлийн 100 аж ахуйн нэгжийн 134 иргэнд Улсын хэмжээнд мөрдөгдөж буй хууль, стандартыг ажлын байран дээр хэрэгжүүлж хэвшүүлэх, цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг зөв дарааллаар хийх арга, дотоод хяналтын журам, бүртгэлийг тогтмол хөтлөлтийн ач холбогдлын чиглэлээр салбарын сургалтыг зохион байгуулсан. "ERDENET FOOD FESTIVAL арга хэмжээг Монгол хоолны соёлыг гадаад, дотоодод таниулах, зочлох үйлчилгээ, хотын соёлыг дээшлүүлэх, орон нутгийн брэнд хоол бий болгох зорилгоор аймгийн хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж буй ресторан, лоунж, кафе, цайны газар, үйлдвэрлэлийн зориулалттай нийтийн хоолны газар, хүнс үйлдвэрлэгчид, технологич, хоол зүйч нарын төлөөлөл зэрэг 30 аж ахуйн нэгж байгууллага оролцож, амжилттай зохион байгууллаа. "АЙМГИЙН АВАРГА ТОГООЧ" шалгаруулах тэмцээнд Орхон аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын 47 тогооч 6 нэр төрөлд ур чадвараа сорин оролцож, 24 байрыг эзлүүлэн шагнаж урамшуулав. "БҮСИЙН АВАРГА ТОГООЧ" шалгаруулах "Гэгээнтний өлгий 2025" ажил мэргэжлийн уралдаан Архангай аймгийн "АРА комплекс"-т 2025 оны 07 дугаар сарын 22-24 өдрүүдэд зохион байгуулж, Орхон аймгаас 9 тогооч оролцон давхардсан тоогоор Алтан цом-1, Алтан медаль-7, Мөнгөн медаль-5, Хүрэл медаль-2 шагналуудыг тус тус хүртсэн.	100 Бүрэн хангалттай

						“УЛСЫН АВАРГА ТОГООЧ,ЗӨӨГЧ” шалгаруулах ур чадварын уралдаан Улаанбаатар хотод 2025 оны 10 дугаар сарын 18–20-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, Орхон аймгаас 12 тогооч оролцож, Алтан цом-1, Алтан медаль-1, Мөнгөн медаль-1, Хүрэл медаль-6, Тусгай байр-3 шалгарч амжилттай оролцсон.	
4.1.5.	Арга хэмжээ 5. Хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийг чадавхжуулах сургалт, туршлага судлуулах	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1 удаагийн туршлага судлуулах, 2 удаагийн сургалт	1-ээс доошгүй	Хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэлийн салбарын бизнес эрхлэгчдийг чадавхжуулах, мэдээллээр хангах сургалт зохион байгуулж, хүнсний худалдаа эрхлэгч 100 аж ахуйн нэгжийн 127, хоол үйлдвэрлэлийн 110 аж ахуйн нэгжийн 134 иргэн хамрагдсан. “Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээнд эрүүл ахуйн болон (GMP, GHP) зохистой дадал хэвшүүлэх нь” сэдэвт сургалтад Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоог нэвтрүүлсэн болон нэвтрүүлж байгаа байгууллагуудын бүтээгдэхүүнийг сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулж, хүнсний үйлдвэрлэл, худалдааны 118 аж ахуйн нэгжийн 158 иргэн, хоол үйлдвэрлэлийн 111 аж ахуйн нэгжийн 142 иргэн хамрагдаж, давхардсан тоогоор 446 аж ахуйн нэгжийг чадавхжуулсан.	100 Бүрэн хангалттай
4.1.6.	Арга хэмжээ 6. Хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүний нөөцийн судалгааг гаргаж, тайлагнах	-	Давтамжийн тоо	7 хоног тутам	7 хоног тутам	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 54 хүнсний үйлдвэр, цех, хүнсний бөөний болон худалдааны төвд байгаа 12 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний нөөцийн мэдээг 7 хоног бүр тогтмол шинэчлэн авч, хүнсний нөөцийн цахим системд мэдээлж байна. 2025 оны 11 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар: улаан буудайн гурил 428.8 тонн, малын мах 589.5 тонн, төрөл бүрийн будаа 115.8 тонн, ургамлын тос 31.7 тонн, давс 25 тонн, элсэн чихэр 28 тонн, төмс 1450.7 тонн, хүнсний ногоо 4315.3 тонн, гурилан бүтээгдэхүүн 96.9 тонн, өндөг 2.2 тонн, хуурай сүү 6 тонн, савласан цэвэр ус 78.9 тонн нөөцтэй байгаа нь жишсэн дундаж нийт хүн амд харьцуулахад гурилын 50 хоног, гурилан бүтээгдэхүүн 6 хоног, малын махны 57 хоног, будааны 27 хоног, ургамлын тос 16 хоног, давс 63 хоног, элсэн чихэр 10	100 Бүрэн хангалттай

						хоног, өндөг 1 хоног, хуурай сүү 4 хоног, төмс 141 хоног, хүнсний ногоо 194 хоногийн нөөцтэй байна.	
4.1.7.	Арга хэмжээ 7. Сургууль, цэцэрлэгийн хүүхдэд өдөр бүр 1 аяга сүүг дотоодын үйлдвэрээс хангах нөхцөлийг бүрдүүлж ажиллах	793.6 Орон нутгийн төсөв	1. Хамрагдсан хүүхдийн тоо 2. Нийлүүлсэн орон нутгийн үйлдвэр, цехийн тоо	1. 2300 2. 2	1. 835 0 2. 2	1.Сурагчдын эрүүл мэндийг дэмжих, сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор 2025 оны 01 дүгээр сараас эхлэн Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэн төрийн өмчийн 17 сургуулийн 6-9 дүгээр ангийн нийт 8353 сурагчид өдөр бүр 180-200 грамм сүү өгч, 2025 оны 10 дугаар сарын 01 хүртэл 793.6 сая төгрөг зарцуулсан байна. 2.Хөтөлбөрийг "Баяжуулагч одод" ХХК, "Сүү" ХК-тай хамтран хэрэгжүүлсэн.	100 Бүрэн хангалттай
Стратеги төлөвлөгөөний зорилго 5. Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг ханган ажиллах үндсэн үүрэг хүлээж, хөнгөн үйлдвэрийн салбарт экспортын баримжаатай болон импортыг орлох бүтээгдэхүүний нэр, төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх, үнэ цэнийн болон кластерын сүлжээг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийг хангах, хөнгөн үйлдвэрийн инновац, технологийн шинэтгэлийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах.							
5.1.	Зорилт 1. Орон нутгийн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг дэмжинэ. /Алсын хараа 2021-2030 БББ 4.5.9., ЗГҮАХ 3.1.3.2., 3.3.4.14., ХХААХҮ-ийн сайдтай байгуулсан 2025 оны гэрээний 4 дүгээр бүлэг, ТЖҮЧ 4.1.8, ЗДҮАХ 3.2.1.4./	-	Дэмжин ажилласан арга хэмжээний тоо	2	2-оос доошгүй	Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа хөнгөн үйлдвэрлэлийн салбарын үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээ борлуулалтыг дэмжих зорилгоор үзэсгэлэн худалдаа, чадавхжуулах сургалт, Цагаан алт хөтөлбөрийг сурталчлах, хөтөлбөрт хамруулж, зээл олгох зэрэг ажлуудыг үр дүнтэй зохион байгуулж ажилласан.	100 Бүрэн хангалттай
5.1.1	Арга хэмжээ 1. Нутгийн брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, сургалт, арга хэмжээ зохион байгуулах	-	1. Арга хэмжээний тоо 2. Бий болсон брэнд бүтээгдэхүүний тоо	1. 1 2. 5	1. 1 2. 5	Хойд бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдааны хүрээнд бүсийн хэмжээнд бараа бүтээгдэхүүнээ сурталчлан таниулах ажил зохион байгуулагдаж бүсийн брэнд бүтээгдэхүүн шалгаруулах уралдаанд Эрдэнэт хивс ХХК-ний хивсэн бүтээгдэхүүн, Эрдмин ХХК-ний цахилгааны уртасгагч, Орда заан хошуу ХХК-ний сүүт нэрийн бүтээгдэхүүн, Баярмөнх наран ХХК-ний Хүндэтгэлийн багц, Өндөрлөг урлан цехийн арьсан цүнх гэсэн 5 бүтээгдэхүүнийг нэр дэвшүүлэн ажилласан. "Egan brend consulting" ХХК-тай хамтран орон нутгийн түүхий эд, нөөц баялгийг ашиглан брэнд бүтээгдэхүүнийг	100 Бүрэн хангалттай

						бий болгох, аймгийн хэмжээнд Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, шинэ зах зээл, шинэ түншлэл бүхий олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, нэр төрлийг олшруулах, өрсөлдөх чадварыг бий болгох, хүн амыг эрүүл аюулгүй, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангах зорилгоор “Брэндээ бүтээ, хамгаал, арчил, үнэ цэнийг өсгө” сэдэвт сургалт, арга хэмжээг зохион байгууллаа. Сургалтад 20 аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцож, 10 аж ахуйн нэгжид бүлгийн болон ганцаарчилсан зөвлөх үйлчилгээ үзүүлж гарын авлага материалаар ханган ажилласан. Сургалтын үр дүнд: 5 аж ахуйн нэгж сав баглаа боодлоо шинэчлэх арга замаа олж, 9 аж ахуйн нэгж оюуны өмчид бүртгүүлэх шийдлээ олсон ба бусад үйлдвэрлэгчид брэндийн талаарх мэдлэг мэдээллээ баяжуулсан үр дүнтэй сургалт болсон.	
5.1.2	Арга хэмжээ 2. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрийг зээлийн бодлогоор дэмжих.	1,100.0 ЖДҮХС 300.0 Орон нутгийн төсөв	1.Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо 2.Олгосон зээлийн хэмжээ /сая.төг/	1. 8 2. 1,300.0	1. 4 2. 400.0	2025 онд ЖДҮХС-аас 10 төсөлд 1.3 тэрбум төгрөг, Атар-4 тариалангийн тогтвортой аяны хүрээнд 5 аж ахуйн нэгж, 7 иргэнд 1.2 тэрбум төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангаас 5 хоршоонд 422.7 сая төгрөг, Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 6 хоршооны 16 малчин өрхөд 529.0 сая төгрөгийн зээл олгосон.	100 Бүрэн хангалттай
5.1.3	Арга хэмжээ 3. "Цагаан алт" үндэсний хөдөлгөөнийг өрнүүлж, хэрэгжилтийг ханган ажиллах, орон нутагт сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулж ажиллах	-	Зохион байгуулсан арга хэмжээ тоо	-	1-2	"Цагаан алт" үндэсний хөдөлгөөнийг өрнүүлж, хэрэгжилтийг хангах, орон нутагт сурталчлан таниулах хүрээнд байгууллагын нээлттэй хаалганы өдөрлөг, малчид тариаланчдын зөвлөгөөнд иргэдэд мэдээлэл өгөхөөс гадна, банкнуудын удирдлагуудтай зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, төрөөс хэрэгжүүлж байгаа Атрын-4 аян, Цагаан алт хөтөлбөр, Шинэ хоршоо хөдөлгөөн, Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөнгөлөлттэй зээл, цаашид хамтран ажиллах талаар мэдээлэл солилцсон.	100 Бүрэн хангалттай

						Арьс шир, ноос ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжүүдэд цагаан алт хөдөлгөөний хүрээнд зохион байгуулагдах хөнгөлөлттэй зээлийн нөхцөлийн талаарх мэдээлэл хүргэж, судалгаа авч Монголын арьс ширний холбоо, Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо, Монголын ноос ноолуурын холбоонд хүргэн ажилласан. Судалгаанд ноос ноолуурын 20 иргэн, аж ахуйн нэгж, арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг 5 аж ахуйн нэгж нийт 25 иргэн, аж ахуйн нэгж хамрагдсан. “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд ноос ноолуурын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 1 аж ахуйн нэгж 188.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан.	
Стратеги төлөвлөгөөний зорилго 6. Жижиг, дунд үйлдвэр, хоршоо, ахуйн үйлчилгээний салбарын үйлдвэрлэл, үйлчилгээний бодлогыг төлөвлөн, зохион байгуулж, санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, импортыг орлох, экспортын боломжийг нэмэгдүүлж, хэрэгжилтийг хангах.							
6.1.	Зорилт 1. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлан таниулах, борлуулалтын сувгийг нэмэгдүүлнэ. /Алсын хараа 2021-2030 БББ 4.5.9., ЗГҮАХ 3.1.3.2., ХХААХҮ-ийн сайдтай байгуулсан 2025 оны гэрээ 5.1., 5.2., ТЖҮЧ 4.1.8, ЗДҮАХ 3.2.1.4./	ЖДҮХС 1,300.0 ХХСан 422.7 ХЭДСан 290.0 ХБИДС 200.0 Орон нутгийн төсөв 3.75	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2	2	Тайлант хугацаанд 10 удаагийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, 280 иргэн аж ахуйн нэгж бизнес эрхлэгчдийн оролцуулан 902.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор бүтээгдэхүүний цахим каталог гаргаж, 80 аж ахуйн нэгжийн 500 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг холбогдох мэдээллийн хамт байршуулан сурталчилж байна.	100 Бүрэн хангалттай
6.1.1	Арга хэмжээ 1. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлан таниулах, борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх зорилгоор туршлага судлах, гадаад дотоодын үзэсгэлэн худалдаанд оролцуулах	0.75 Орон нутгийн төсөв	Зохион байгуулсан үзэсгэлэнгийн тоо	2	2-оос доошгүй	-Цагаан сарын баярыг угтсан 5 удаагийн үзэсгэлэн худалдаанд түрээсийн төлбөргүйгээр 280 иргэн аж ахуйн нэгжийг оролцуулж 2500 нэр төрлийн бүтээгдэхүүн худалдан борлуулж 300.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. -Хойд бүсийн бизнес эрхлэгчдийн уулзалт зөвлөгөөний үйл ажиллагаатай холбогдуулан Орхон, Булган, Хөвсгөл аймгуудын хөнгөн, жижиг дунд үйлдвэр, хоршоодын үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний үзэсгэлэнг зохион байгуулсан. Арга хэмжээнд Орхон аймгаас 25 иргэн аж ахуйн нэгж, иргэн	100 Бүрэн хангалттай

						оролцуулж, бүсийн хэмжээнд бараа бүтээгдэхүүнээ сурталчлан таниулж бараа бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ хийх, захиалга авах бартер хийх зэрэг ажлууд хийгдсэн. - "Дэлхийн Жижиг, дунд үйлдвэрийн өдөр-2025" арга хэмжээ Улаанбаатар хотод зохион байгуулагдаж орон нутгийн 7 аж ахуйн нэгж 280 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 35.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. - Нүүдэлчин фестивальд 15 иргэн, аж ахуйн нэгж 280 нэр төрөл бүтээгдэхүүнээр оролцож 45.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Орон нутгийн төсвөөс 750.0 мянган төгрөг зарцуулсан. - "Зэс фестиваль-2025" арга хэмжээнд 18 аж ахуйн нэгж оролцож 300.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. - "Намрын ногоон өдрүүд, Үндэсний үйлдвэрлэл -2025" арга хэмжээнд 15 иргэн, аж ахуйн нэгж оролцож 102.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. байна. ҮР ДҮН: 10 удаагийн үзэсгэлэн арга хэмжээнд талбайн түрээс болон татвар хураамжгүйгээр үйлдвэр эрхлэгчдийг оролцуулж, нийтдээ 902.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.	
6.1.2	Арга хэмжээ 2. Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлд хамруулах.	ЖДҮХС 1,300.0 ХХСан 422.7 ХЭДСан 290.0 ХБИДС 200.0	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээнд олгосон зээлийн хэмжээ /сая.төг/	ЖДҮ сан 1,300.0, ХХСан 250.0	500.0	ЖДҮХС-аас 10 аж ахуйн нэгжид 1.3 тэрбум төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангаас 5 хоршоонд 422.7 сая төгрөгийн зээл олгосон. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 3 жилийн хугацаатай хүүгүй, барьцаагүй зээлийг 29 иргэнд 290.0 сая төгрөгийн зээл олгосон. Хөгжлийн бэрхшээлтэй 20 иргэнд 200.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.	100 Бүрэн хангалттай
6.1.3	Арга хэмжээ 3. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээл авсан аж ахуйн нэгжүүдэд хяналт, шалгалт хийх	3.0 Орон нутгийн төсөв	Хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо	20	26	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2019-2025 онуудад 38 аж ахуйн нэгжид 4.9 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Зээл олгосон аж ахуйн нэгжүүдийн зээлийн зориулалт, үйлдвэрийн үйл ажиллагаа, зээлийн эргэн төлөлт зэрэгт жил бүр хяналт мониторинг хийж ажилласан. Зээлд хамрагдсан аж ахуйн нэгжүүд төслийн санхүүжилтээр тоног төхөөрөмжөө шинэчлэх, үйлдвэрийн байраа өргөтгөж тохижуулах, сав баглаа боодлоо шинэчлэх, түүхий эдийн нөөцөө бэлтгэх	100 Бүрэн хангалттай

						зэрэг хөрөнгө оруулалтын болон эргэлтийн хөрөнгөнд зарцуулсан байна. Хяналт хийхдээ зээлийн хяналтын тайлан бөглүүлж санхүүгийн тайлан, татвар, нийгмийн даатгалын тайлан, дансны хуулга зэргийг авч зээлийн программд оруулсан. Зээлд хамрагдахаас өмнө болоод дараах үеийн харьцуулалтыг хийж үзэхэд зээлд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлого 3 дахин нэмэгдсэн ба 105 ажлын байр шинээр бий болж 168 ажлын байр хадгалагдсан байна. Хяналт мониторингийн явцад 4 зээлдэгчийн 70.3 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлт хугацаа хэтэрсэн байсныг 44.1 сая төгрөгийн төлөлт хийлгэж, 3 зээлдэгч хэвийн ангилалд орсон. Үлдсэн нэг зээлдэгчийн төлөлтийг 12 сард бүрэн төлж дуусгахаар амлалт авч ажиллаж байна.	
6.1.4	Арга хэмжээ 4. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн цахим каталог хийж, бараа бүтээгдэхүүнийг сурталчлах	-	1.Цахим каталогид хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо 2.Бараа бүтээгдэхүүний тоо	-	1. 25-аас доошгүй, 2. 30-аас доошгүй	Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор бүтээгдэхүүний цахим каталог гаргаж, 80 аж ахуйн нэгжийн 500 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг холбогдох мэдээллийн хамт байршуулсан. Цахим каталогийг сард дунджаар 1400 хүн үзэж сонирхсон байна. Цахим каталог гаргаснаар Өмнөговь, Дорнод, Баянхонгор, Хэнтий аймгуудаас 23 хос бүтээгдэхүүний худалдан борлуулалт хийж, Швед, Солонгос улсаас 80 хос бүтээгдэхүүний захиалга авсан.	100 Бүрэн хангалттай
6.2.	Зорилт 2. Ахуйн үйлчилгээний салбарын бизнес эрхлэгчдийг дэмжин, үйлчилгээний чанарыг сайжруулах. /Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, ХХААХҮ-ийн сайдтай байгуулсан 2025 оны	8.0 Орон нутгийн төсөв	1.Мэдээллийн сангийн баяжилт /нэр төрөл/ 2. Чадавхжуулах сургалтын тоо 3. Тохирлын үнэлгээнд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо	1.365 цэг 2. 4 3. 5	1. 370 2.1-ээс доошгүй 3. 3	1. 2025 онд шинээр 19 цэг нэмэгдэж аймгийн хэмжээнд ахуйн үйлчилгээний салбарт 338 цэгт аж ахуй нэгж, иргэн үйл ажиллагаа явуулж байгаагийн 14 буюу 4.1 хувь нь нийтийн халуун ус, 87 буюу 25.7 хувь нь үсчин, гоо сайхан, 87 буюу 25.7 хувь нь хувцас захиалга, засвар, 70 буюу 20.7 хувь нь авто машины засвар, 19 буюу 5.6 хувь нь авто машины угаалга, 6 буюу 1.8 хувь нь ахуйн электрон, цахилгаан хэрэгсэл засвар, 10 буюу 3.0 хувь нь гутал захиалга, засвар, 19 буюу 5.6 хувь нь гэр ахуйн модон эдлэл захиалга, засвар, 7 буюу 2.1 хувь нь алт, мөнгө, үнэт эдлэлийн захиалга, засвар, 19 буюу 5.6 хувь нь бусад үйлчилгээний чиглэлээр тус тус үйл ажиллагаа	100 Бүрэн хангалттай

	гэрээний 5.5, ЗДҮАХ 3.2.1.4., ЗДҮАХХАХТ/					явуулж байна. Өмнөх оноос хувцас засвар, гутал засвар, гэр ахуйн модон эдлэл эрхлэгч 46 иргэн үйл ажиллагаагаа зогсоогоод байна. 2.Үсчин, гоо сайханчдыг чадавхжуулах, мэдлэг олгох 2 удаагийн сургалт, Улсын зөвлөгөөн зохион байгуулж давхардсан тоогоор 314 хүнийг хамруулсан. 3. Стандартын шаардлага хангасан үс засах үйлчилгээ, алжаал тайлах бариа заслын үйлчилгээ эрхэлдэг 14 аж ахуйн нэгж байгууллагад 1-2 жилийн хугацаатай тохирлын гэрчилгээ олгосон.	
6.2.1	Арга хэмжээ 1. Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах.	2.0 Орон нутгийн төсөв	Сургалт зохион байгуулсан тоо	4	3	Мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 1, Дэлхийн аварга, алтан цомын эзэн, Монгол улсын мастер гоо засалч А.Магнайн туршлагаас 1, BARBER BATTLE чиглэлээр 1, нийт 3 удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 88 хүнийг хамруулсан. Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Монголын Үсчин, гоо засалчдын холбоотой хамтран “Монголын Үсчин Гоо Сайхны Хөгжил-2030” чуулганыг Эрдэнэт хотдоо амжилттай зохион байгуулж, 12 аймгийн холбоод, 200 салбарын ажиллагсад оролцсон.	100 Бүрэн хангалттай
6.2.2	Арга хэмжээ 2. Үсчин, гоо засалчдын мэргэжлийн ур чадварын аймгийн аварга шалгаруулах тэмцээн, уралдааныг зохион байгуулах.	4.0 Орон нутгийн төсөв	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	1	Монголын Барбер Холбоо, Үсчин, гоо засалчдын холбоотой хамтран Орон нутгийн төсвийн 2.0 сая төгрөгөөр үсний тайралт, хэв маяг оруулалт, үс засалтыг сурталчлан таниулах, харилцан суралцаж, хамтдаа хөгжих зорилгоор "MONGOLIAN OLD SCHOOL BARBER BATTLE 2025" аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр QUEEN BARBERSHOP салонд зохион байгуулсан. Тэмцээний өмнө эрэгтэй үс заслын 24 үсчинд сургалт зохион байгуулж мэдлэг олгосон. Тэмцээнд 14 оролцогч 6 төрлөөр өрсөлдөж шилдгүүдээ тодруулсан. Эрдэнэтийн ээжүүдийг чадавхжуулах холбоо, Оёдлын холбоотой хамтран Орон нутгийн төсвийн 2.0 сая төгрөгөөр “Баяр наадмын гангараа” үзэсгэлэн худалдааг	100 Бүрэн хангалттай

						хоёр өдөр Амарын талбайд зохион байгуулж, Үндэсний хувцас, гоёл чимэглэл, баяр наадамтай холбогдуулан урласан урлаачдын бүтээлийг нэг дороос худалдан авах боломжийг бүрдүүлж ажилласан. “Уран гар-2025” уралдаанд давхардсан тоогоор 40 гаруй урлаач оролцож шилдгүүдээ шалгаруулсан.	
6.2.3	Арга хэмжээ 3. Явуулын ахуйн үйлчилгээг зохион байгуулах.	1.0 Орон нутгийн төсөв	1.Хамрагдсан хүний тоо 2.Борлуулалтын орлого /сая.төг/	1. 185 2. 1.8	1. 150 3. 1.5	Жаргалант сумын иргэдэд ахуйн үйлчилгээний салбарын үйлчилгээг зах зээлийн үнээс хямд, нэг цэгээс хүргэн үйлчлэх, иргэдийн зардлыг хэмнэх, үйлчилгээ эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор "Явуулын ахуйн үйлчилгээг" Жаргалант суманд зохион байгуулж, үс засах, хумс засал, сормуус суулгах, гутал засвар, цахилгаан бараа засварын чиглэлээр давхардсан тоогоор 160 гаруй хүнд үйлчилгээ үзүүлсэн. Дээрх үйл ажиллагааны хүрээнд 1.6 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн.	100 Бүрэн хангалттай
6.2.4	Арга хэмжээ 4. Ахуйн үйлчилгээний чанар, стандартын хэрэгжилтийн түвшинг дээшлүүлэхэд сургалт, сурталчилгааг зохион байгуулж, тохирлын үнэлгээнд хамруулах.	1.0 Орон нутгийн төсөв	Тохирлын үнэлгээнд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо	5	3	Баян-Өндөр сумын ЗДТГ, Үсчин, гоо засалчдын холбоотой хамтран үсчин, гоо сайхны үйлчилгээнд мөрдөгдөж байгаа “Үс засах үйлчилгээ” MNS 5160:2020, “Хумс заслын үйлчилгээ” MNS 6843:2020 стандартыг сурталчлах, таниулах, чадавхжуулах сургалтыг 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулж сургалтад 83 хүн хамрагдаж, дараах чиглэлийн мэдлэг олгосон. 1. Эрх зүйн зохицуулалт, стандартын тухай үндсэн ойлголт 2. Эрүүл ахуй, халдвар хамгааллын тухай ойлголт 3. Гоёлын гоо засал, хумс заслын үйлчилгээний газрын зэрэглэл, мэргэжлийн зэрэг түвшний мэдээлэл 4. Үс засах үйлчилгээний газрын зэрэглэл, мэргэжлийн зэрэг түвшний мэдээлэл 5. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухайн ойлголт 6. Нийгмийн даатгалын багц хууль 7.Гал түймрээс урьдчилан сэргийлэх 2.Үүний үр дүнд стандарт хэмжилзүйн хэлтэст ирүүлсэн хүсэлтийн дагуу үс засах үйлчилгээ, алжаал тайлах	100 Бүрэн хангалттай

						бариа заслын үйлчилгээ эрхэлдэг 14 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай танилцаж, “Үс засах үйлчилгээ” MNS 5160:2020 стандартын үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэн мэргэжлийн зөвлөмж туслалцаа үзүүлж, ажлын хэсгийн дүгнэлтээр 2 жилийн хугацаатай тохирлын гэрчилгээг олгосон.	
6.3.	Зорилт 3 “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хэрэгжилтийг эрчимжүүлэх, зээлийн дэмжлэгт хамруулах. /ЗГҮАХ 3.3.4.1., 3.3.4.3., 3.3.4.4., ХХААХҮ-ийн сайдтай байгуулсан 2025 оны гэрээ 5.3.,5.4., ЗДҮАХ 3.5.2.1./	529.0 Улсын төсөв 8.0 Орон нутгийн төсөв	Зээлд хамрагдсан хоршооны тоо	40	2	“Шинэ хоршоо хөдөлгөөн”-ний хүрээнд 47 хоршооны 174 малчин 6.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлд хамрагдсан байна. Үүнээс 2025 оны байдлаар хөдөө аж ахуйн чиглэлийн 203 гишүүнтэй 23 хоршоо шинээр байгуулагдаж, 6 хоршооны 16 малчин 529.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлд хамрагдан үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Сургалт, зөвлөгөөн, чуулган, туршлага судлуулах зэргээр орон нутгийн төсвийн 8.0 сая төгрөгөөр дэмжин чадавхжуулсан. Үүнээс Өмнөх онд зээл авсан хоршоодын үйл ажиллагаанд хяналт хийхэд 500,000 төгрөг, хоршоодын сайн туршлагыг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулахад 1,000,000 төгрөг зарцуулсан.	100 Бүрэн хангалттай
6.3.1	Арга хэмжээ 1. Аймгийн хоршоологчдын зөвлөгөөнийг зохион байгуулах	Орон нутгийн төсөв 2.0	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	1	1. Хойд бүсийн хоршоологчдын зөвлөгөөн, Засгийн газрын өргөтгөсөн худалдаан Булган аймагт зохион байгуулагдаж, Орхон аймгаас хоршооны 20 төлөөллийг нэгдсэн удирдлагаар ханган оролцуулсан. 2.Монголын Хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооноос Монгол орны хоршооллын хөдөлгөөний хөгжлийг эрчимжүүлэх, хоршооллын салбарын хүний нөөцийг чадавхжуулах, хоршооллын байгууллагуудын өмнө тулгамдаж буй асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх боломжийг эрэлхийлэх зорилгоор Хөдөө аж ахуйн хоршоологчдын Улсын зөвлөгөөнийг “Дундын хоршоо ба бизнес түншлэл” сэдвийн хүрээнд зохион байгуулж, 20 аймаг, нийслэлийн 160 гаруй хүн оролцсон байна. Орхон аймгаас хоршооллын 13 гишүүн оролцсон.	100 Бүрэн хангалттай

6.3.2	Арга хэмжээ 2. Хоршоодыг чадавхжуулах сургалт зохион байгуулах.	Орон нутгийн төсөв 2.0	Чадавхжуулах сургалтад хамрагдсан хоршоо эрхлэгчдийн тоо	6 удаагийн сургалтад давхардсан тоогоор 170	3 удаагийн сургалтад 180	1.Хүнс, хөдөө аж ахуйн газар, Сумдын Засаг даргын Тамгын газар, Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоо, Нийгмийн түншлэлийн сүлжээ ТББ-тай хамтран хоршоодыг чадавхжуулах, мэдлэг олгох зорилгоор 5 удаагийн сургалтыг давхардсан 131 хүнийг хамруулсан. Сургалтаар •Хоршооны үйл ажиллагааны төлөвлөгөө • Хоршооны сул талууд • Маркетингийн үндсэн ойлголтууд • Маркетингийн хольц • Бизнес тоглоом -1 • Өртгийн сүлжээ • Цагийн менежмент •Нөлөөллийн үйл ажиллагааг хөгжүүлэх нь •Манлайлагчийн зан чанар ба ур чадвар гэх мэт чиглэлээр мэдлэг олгосон. 2.“Хариуцлагатай, тогтвортой хоршоо” төслийн хүрээнд хоршоог чадавхжуулах, хоршоо байгуулах сонирхолтой өрхийн үйлдвэрлэл эрхлэгч иргэдэд хоршооны анхан шатны мэдлэг олгох 9 удаагийн сургалтыг зохион байгуулж, 26 багийн 125 бизнес эрхлэгчийг хамруулсан. Нийт 14 удаагийн сургалтад 256 хүнийг хамруулж ажилласан.	100 Бүрэн хангалттай
6.3.3	Арга хэмжээ 3. Салбарын туршлага судлах арга хэмжээ зохион байгуулах	Орон нутгийн төсөв 2.5	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	1	Жижиг, дунд үйлдвэрийн газраас зохион байгуулсан "Хоршоологчид тогтвортой хөгжилд-2025" хоршоологчдын туршлага судлах аялал Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд зохион байгуулагдаж, Орхон аймгаас хоршооны төлөөлөл 4 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон. Энэхүү туршлага судлах арга хэмжээ нь хоршоодын үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, орон нутгийн гаралтай бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, хоршооллын хөгжлийг дэмжихэд чухал ач холбогдолтой үйл явдал болсон.	100 Бүрэн хэрэгжсэн
Стратегийн зорилго 7. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлыг хангуулна.							

7.1.	Зорилт 1. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлыг хангуулна. /Алсын хараа 2021-2030 БББ 9.2.3., 2.5.14., 2.5.15., 2.5.18., ЗГҮАХ 3.3.4.26., ХХААХҮ-ийн сайдтай байгуулсан 2025 оны гэрээний 3 дугаар бүлэг, ЗДҮАХ 3.5, 3.5.1./	10.0 Орон нутгийн төсөв	1. Шалгалт хийсэн объектын тоо 2. Эрсдэл үүсэх магадлалын хувь	1. 516 2. 14.9 хувь	1. 507 2. 14.5 хувь	2025 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөт хяналт шалгалт-54, төлөвлөгөөт бус-76, урьдчилан сэргийлэх хяналт-542, нийт 672 объектод хийсэн. Хяналт шалгалтаар 963 зөрчлийг илрүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч газар дээр нь 754 зөрчил буюу 78.2 хувийг арилгуулж, 69 аж ахуйн нэгжид Улсын ахлах байцаагчийн дүгнэлтийг үйлдэж ажилласан. Илэрсэн зөрчилтэй холбогдуулан 29 аж ахуйн нэгж, 2 иргэнд 211 заалт бүхий албан шаардлага хүргүүлж, биелэлт 89 хувьтай дүгнэгдсэн. Хяналт шалгалтын үр дүнд нийт 653 зөрчлийг арилгуулж, 2024 онтой харьцуулахад эрсдэл 5.2 хувиар буурсан, Хууль тогтоомжийн хэрэгжилт 5.2 хувиар өсөж, 90.5 хувьд хүрсэн байна. 2025 оны хяналт шалгалтын үйл ажиллагаа төлөвлөгөөний дагуу хэрэгжиж, илэрсэн зөрчлийн ихэнхийг газар дээр нь арилгуулсан бөгөөд байгууллагын хяналтын үр нөлөө сайжирч, эрх зүйн хэрэгжилт өссөн нь эерэг дүнтэй байна. Эрсдэлийн түвшин буурсан нь мэргэжил арга зүйн зөвлөгөө, урьдчилан сэргийлэх хяналтын ажил үр дүнтэй байсныг харуулж байна.	100 Бүрэн хангалттай
7.1.1	Арга хэмжээ 1. Бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд батлагдсан шалгуурын дагуу эрсдэлийн үнэлгээ хийх	-	Эрсдэлийн үнэлгээ хийгдсэн объектын тоо	460	470	Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд батлагдсан 9 шалгуур үзүүлэлтийн дагуу 472 объектод эрсдэлийн эрсдэлийн үнэлгээ хийж, 289 объект буюу 61.2 хувь нь бага эрсдэлтэй, 110 объект буюу 23.3 хувь нь дунд эрсдэлтэй, 73 объект буюу 15.5 хувь нь их эрсдэлтэй үнэлэгдсэн. 2026 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх 61 объектын төслийг хүргүүлж ажилласан.	100 Бүрэн хангалттай
7.1.2	Арга хэмжээ 2. Их болон дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийх.	-	Шалгалт хийсэн объектын тоо	56	57	Салбарын Улсын Ерөнхий байцаагчийн баталсан 4 удирдамжийн дагуу төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2025 онд 57 объект хамруулахаас 54 буюу 95 хувьд хийж гүйцэтгэсэн. 2 аж ахуйн нэгж, 1 иргэн үйл ажиллагаа эрхлээгүй. Шалгалтаар бага эрсдэлтэй 53 объект, дунд эрсдэлтэй 1 объект - Хууль сахин мөрдөлтийн түвшин 92.5хувь	100 Бүрэн хангалттай

						- Эрсдэл үүсэх магадлал 7.5 хувь - Зөрчлийн тоо 275, үүнээс 219 зөрчлийг газар дээр арилгуулж илэрсэн зөрчлийг нь арилгуулахаар Улсын ахлах байцаагчийн 12 заалт бүхий 2 албан шаардлага, Улсын байцаагчийн 24 заалт бүхий 2 албан шаардлага хугацаатай хүргүүлж, зөрчлийг гүйцэтгэлийн хяналтаар арилгуулсан. Хүрсэн үр дүн: 2024 онтой харьцуулахад эрсдэл 5.2 хувиар буурч, Хууль тогтоомжийн хэрэгжилт 5.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	
7.1.3	Арга хэмжээ 3. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын өргөдөл, гомдлын дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийж, эрсдэлийг бууруулах	-	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь	100 хувь	100 хувь	Аж ахуйн нэгж, байгууллагаас албан бичиг-39, иргэдээс өргөдөл, хүсэлт, гомдол- 110 ирүүлснийг хуулийн хугацаанд 100 хувь бүрэн шийдвэрлэж ажилласан. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмших хүсэлт ирүүлсэн 69 аж ахуйн нэгж, шинээр хүнсний үйлдвэрлэл, хоол үйлдвэрлэл, худалдаа эрхлэх хүсэлтэй 80 нийт 149 объектод төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Стандартын шаардлага хангасан 69 аж ахуйн нэгжид Улсын ахлах байцаагчийн дүгнэлтийг үйлдэж ажилласан.	100 Бүрэн хангалттай
7.1.4	Арга хэмжээ 4. Нийтийг хамарсан баяр ёслол, цаг үеийн шаардлагаар урьдчилан сэргийлэх шалгалт хийх.	-	Шалгалт хийсэн объектын тоо	340	450	Салбарын Улсын Ерөнхий байцаагчийн баталсан удирдамжийн дагуу 4 хяналтын чиглэлээр нийт 548 объектод урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн. Шалгалтын үр дүнд: 376 зөрчлийг илрүүлж, 271 буюу 72%-ийг газар дээр нь арилгуулсан. Давхардсан тоогоор хүнсний чиглэлийн 297 аж ахуйн нэгж, 627 иргэдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. Илэрсэн зөрчилтэй холбогдуулан 7 аж ахуйн нэгжид 74 заалт бүхий Улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлж, биелэлтийг хангуулж ажилласан. Биелэлтийг гүйцэтгэлийн хяналт шалгалтаар шалгахад 67 зөрчлийг арилгуулж, хууль тогтоомжийн хэрэгжилт 89 хувьд хүрсэн.	100 Бүрэн хангалттай
7.1.5	Арга хэмжээ 5. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд	-	Эрсдэл үүсэх магадлалын хувь	14.9 хувь	14 хувь	Хяналт шалгалтаар 963 зөрчлийг илрүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч газар дээр нь 754 зөрчил буюу	100 Бүрэн хангалттай

	төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх.					78.2 хувийг арилгуулж, 69 аж ахуйн нэгжид Улсын ахлах байцаагчийн дүгнэлтийг үйлдэж ажилласан. Илэрсэн зөрчилтэй холбогдуулан 29 аж ахуйн нэгж, 2 иргэнд 211 заалт бүхий албан шаардлага хүргүүлж, биелэлт 89 хувьтай дүгнэгдсэн. Эрсдэл үүсэх магадлал 3.8 хувиар буурч 11 хувьд хүрсэн.	
7.1.6	Арга хэмжээ 6. Мах, махан бүтээгдэхүүн, өндөг, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл шинээр эрхлэгчдэд урьдчилсан хяналт хийж, дүгнэлт гаргах	-	Шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээний тоо	3 объект	Хүсэлтийн тоогоор	Хагас боловсруулсан махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүсэлтэй 4 аж ахуйн нэгж, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх хүсэлтэй 2 аж ахуйн нэгж, нийт 6 аж ахуйн нэгжээс ирүүлсэн хүсэлтийн дагуу холбогдох хяналтын хуудсаар урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийхэд тус 6 үйлдвэрийн ажлын байр нь “бага” эрсдэлтэй үнэлэгдсэн тул ажлын байрны дүгнэлт олгосон.	100 Бүрэн хангалттай
7.1.7	Арга хэмжээ 7. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд чиглэсэн сургалт зохион байгуулах.	-	Сургалтын тоо	3	3	Хүнсний чанар, аюулгүй байдлыг хангах, газар тариалангийн салбарын хууль, эрх зүйн орчны шинэчлэл, хэрэгжилтийг сайжруулах зорилгоор хүнсний худалдаа эрхлэгч 100 аж ахуйн нэгжийн 127 иргэн, хоол үйлдвэрлэлийн үйлчилгээ эрхлэгч 111 аж ахуйн нэгжийн 134 иргэн, тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 40 иргэн, нийт 201 хүнийг хамруулан 3 удаагийн сургалтыг Эдийн засгийн ногоон шилжилт төсөл, “Трейд ментор” сургалтын төв, “Proliance” ХХК, Монгол Улсын Зөвлөх агрономич Б.Энхбаяртай гэрээ байгуулан хамтран зохион байгуулсан. Сургалтыг зохион байгуулснаар хууль, эрх зүйн мэдлэг дээшилж, бүртгэл хөтлөлт, хууль, журам, стандартын хэрэгжилт 2024 оны мөн үетэй харьцуулахад 5 хувиар нэмэгдэж, 94.5 хувьд хүрсэн.	100 Бүрэн хангалттай
7.1.8	Арга хэмжээ 8. Хяналт шалгалтын үйл ажиллагаа, үр дүнг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд сурталчлах.	-	1.Телевизээр нэвтрүүлсэн мэдээллийн тоо 2.Сурталчилгааны тоо	1. 8 удаа 2. Цахим сайт, пэйж хуудсаар-4 удаа	1. 4 удаа 2.Цахим сайт, пэйж хуудсаар-4 удаа	Иргэдэд хүнсний эрүүл ахуй, чанар аюулгүй байдлын шаардлага хангасан бараа, бүтээгдэхүүн худалдан авах, хэрэглэгчийн хяналтыг сайжруулах, хүнсний аюулгүй байдлын аяны шалгалтын явцын мэдээг орон нутгийн 4 телевиз, 4 сайтад өгч ажилласан. Хүнсний зөв хэрэглээ, хадгалалт, худалдан авалт болон сонголтын чиглэлээр анхаарах асуудлын талаар 12 постер, 1 богино хэмжээний бичлэг, 9 төрлийн гарын авлага гаргаж байгууллагын пэйж хуудсанд 4 удаагийн давтамжтайгаар	100 Бүрэн хангалттай

						байршуулж, хэрэглэгчийн боловсролыг дээшлүүлэн, соён гэгээрүүлж, мэдээллийг түгээж ажиллалаа. Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр олон нийтэд мэдээлэл, зөвлөмж түгээж, сурталчилсны үр дүнд өргөдөл гомдол өмнөх оноос 3 хувиар буурсан.	
7.1.9	Арга хэмжээ 9. Shilenkhyanalt.gov.mn, https://www.igov.mn -д хяналт, шалгалтын тоон мэдээ, иргэн аж ахуйн нэгжийн бүртгэл оруулах, лавлагаа авах.	-	Бүртгэсэн аж ахуй нэгжийн тоо	135	Хүсэлт ирүүлсэн тухай бүрд	Шинээр хүнс худалдаа, хоол үйлдвэрлэл, хүнсний үйлдвэр, газар тариалан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн худалдаалах шинээр үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй 80 аж ахуйн нэгж, иргэнийг https://www.igov.mn цахим бүртгэж бүртгэлийн хуудсыг олгосон.	100 Бүрэн хангалттай
БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ						Бүрэн хангалттай	97.5%

--oOo--

ХАВСРАЛТ №1. БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ТӨСӨВ

№	Зардлын зүйл анги	Төлөвлөгөө /мян.төг/	Гүйцэтгэл 11 сараар /мян.төг/
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	647,536.2	639,738.8
2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,918.0	80,940.6
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	72,634.2	59,754.6
4	Хангамж, бараа материалын зардал	11,506.8	6,464.4
5	Нормативт зардал	551.7	0
6	Эд хогшил, урсгал засварын зардал	23,639.7	15,079.5
7	Томилолт, зочны зардал	8,000.0	4,794.8
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	61,539.9	24,550.0
9	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	47,208.0	100.0
10	Бараа, үйлчилгээний бусад зардал	2,705.4	1,161.4
Нийт төсвийн дүн		957,239.9	832,584.1

--oOo--